

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ЖДҮХС-гийн 2019, 2020 оны үйл ажиллагаа
Дорнод аймагт үр нөлөөгөө өгөөгүй байна.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**“Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үйл
ажиллагааны үр нөлөө”-нд хийсэн аудитын тайлан**

АУДИТЫН КОД: ДОА-2022/32-ШТА-ГА

Чойбалсан хот
2022 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор Я.Зориг
Утас: 7058-4207, Цахим хаяг: zorigya@audit.gov.mn
Аудитор С.Энхбаатар
Утас: 7058-4207, Цахим хаяг: enkhbaatarsu@audit.gov.mn
Аудитор Ч.Удвалноров
Утас: 7058-4207, Цахим хаяг: udvalnorovch@audit.gov.mn
Аудитор М.Ганбилэг
Утас: 7058-4207, Цахим хаяг: ganbilegm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

Аудитын тайланг бэлтгэсэн:	АГУУЛГА
Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар	Товчилсон үгийн тайлбар.....3
Аудитын II баг	Хүснэгт, дүрслэлийн тоёог.....4
Дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....7
Аудитын менежер: И.Сэмжидмаа	Бүлэг 1. Орон нутагт ЖДҮ-г хөгжүүлэх эрх зүйн орчин хангалттай бүрдээгүйгээс кластераар хөгжүүлэх бодлого, төрийн зарим байгууллагын бүтэц чиг үүрэг, санхүүжилтийн төлөвлөлт зэрэг асуудлууд оновчтой тодорхойлогдоогүй байна.....7
Ахлах аудитор: Я.Зориг	1.1. Орон нутагт ЖДҮ-г хөгжүүлэх эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй байна.....7-11
Аудитор: С.Энхбаатар Ч.Удвалноров М.Ганбилэг	1.2. Аймгуудад олгох ЖДҮ-ийн санхүүжилтийг төлөвлөхдөө бодит хэрэгцээ, шаардлага, тооцоо судалгаанд үндэслээгүй байна.....12-14
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7058-4203, 7058-4207 утсаар лавлана уу.	Бүлэг 2. ЖДҮХС болон аймгийн ЖДҮ-ийн зарим зээлүүд зориулалт бусаар үр дүнгүй зарцуулагдсан байна.....15
Хаяг: Дорнод аймаг, Хэрлэн сум, 7-р баг, аймгийн ЗДТГ-ын II байр, 03 тоот	2.1. Дэд хороо журмын дагуу байгуулагдсан ч чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.....15-19
2022 оны 11 дүгээр сар	2.2. ЖДҮ-ийн чиглэлээр олгосон зарим зээлүүд зориулалт бусаар үр дүнгүй зарцуулагдсан байна.....20-22
	Бүлэг 3. Хөтөлбөр, төслүүд зорилтот түвшиндээ хүрээгүй, орон нутагт үр өгөөжөө өгөөгүй байна.....23
	3.1. Хэрэгжсэн төслүүд зорилтот түвшиндээ хүрээгүй нь ЖДҮ-ийн зээлийн үр нөлөөг бууруулж байна.....23-28
	3.2. Хөтөлбөр, төслийн хэрэгжилт хангалтгүй, хяналт үр нөлөө багатай байна.....28-29
	Холбогдох байгууллагын санал:.....30
	Саналд өгсөн тайлбар:30
	ДҮГНЭЛТ:31
	САНАЛ:32
	ЗӨВЛӨМЖ:32-33
	ТУШААЛ:34-38

Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУБ	Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага
АДБОУС	Аудит дээд байгууллагуудын олон улсын стандарт
АЗДТГ	Аймгийн Засаг даргын Тамгын газар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДОА	Дорнод аймаг
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэр
ЖДҮГ	Жижиг, дунд үйлдвэрийн газар
ЖДҮҮЭ	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч
ЖДҮХС	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
СЯ	Сангийн яам
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХХААХҮ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХШҮ	Хяналт-шинжилгээ үнэлгээ
MNS	Mongolian national standard
SMART	S-Specific, M-Measurable, A-Attainable, R-Realistic, T-Timely
SWOT	S-Strength, W-Weakness, O-Opportunity, T-Threat

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Дорнод аймгийн ЖДҮ-ийн өнөөгийн байдалд хийсэн SWOT шинжилгээ	9
Хүснэгт 2	Дотоодын нийт бүтээгдэхүүний салбарын бүтэц, хувиар	10
Хүснэгт 3	Дорнод аймгийн эдийн засгийн үзүүлэлтүүд	12
Хүснэгт 4	Зээл олгох журмын сангаар болон банкаар дамжуулан олгох зээлд зарцуулах хугацааны харьцуулалт	13
Хүснэгт 5	Аж ахуйн нэгжүүдийн ажиллагчдын ангилал	13
Хүснэгт 6	2019 онд олгосон төслүүдийн харьяалагдах салбар, чиглэл	16
Хүснэгт 7	2020 онд олгосон төслүүдийн харьяалагдах салбар, чиглэл	16

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	2019-2020 онд олгосон төслүүдийн харьяалагдах салбар, чиглэл	17
Дүрслэл 2	Төсөл сонгон шалгаруулалтын үнэлгээний явц 2019-2020 он	17
Дүрслэл 3	ХХААГ-т бүртгэлтэй шинээр байгуулагдсан үйлдвэрийн судалгаа 2018-2020	25
Дүрслэл 4	ААН, иргэдийн төслийн үйл ажиллагааны судалгаа – ЖДҮХС	26
Дүрслэл 5	ААН, иргэдийн төслийн үйл ажиллагааны судалгаа – Аймгийн ЖДҮ	26
Дүрслэл 6	ЖДҮХС - 2019, 2020 оны ажлын байрны судалгаа	27
Дүрслэл 7	Аймгийн ЖДҮ-ийн 2019, 2020 оны ажлын байрны судалгаа	28

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Аудитын сэдэв батлах тухай” 6 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2022 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн хийлээ.
Аудитын зорилт	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны үр нөлөөг тооцож, дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэнэ. Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэнэ. Үүнд: 1. Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр төрөөс баримталж буй бодлого, эрх зүйн зохицуулалтад ЖДҮХС-ийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, үр дүн, үр нөлөөг тооцох асуудал зохих түвшинд тодорхойлогдсон эсэх; 2. ЖДҮ-ийн сонгон шалгаруулалт, зээлийн зориулалт, зарцуулалт хууль тогтоомж, дүрэм журам зэрэг холбогдох шаардлага, шалгуурын дагуу үр дүнтэй хэрэгжсэн эсэх; 3. Хөтөлбөр, төслүүд зорилтот түвшиндээ хүрч, орон нутагт үр өгөөжөө өгсөн эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймгийн ИТХ, Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, ЖДҮ хариуцсан мэргэжилтнүүд, ЖДҮХС-аас зээл олгох, төсөл сонгон шалгаруулах дэд хороо, Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв, арилжааны банкууд, ЖДҮХС-ийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн 2019-2020 оны үйл ажиллагааг хамруулав. Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэн аудитын дэд тайлан, илрүүлэлтийн матрицыг боловсруулан Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлэн тус газар нь гүйцэтгэлийн аудитын үр дүнг Монгол Улсын Ерөнхий аудиторт танилцуулна.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторов 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан тэдгээрийн нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийх арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим сорил, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

**Хүндрэл,
бэрхшээл**

Аудитад дараах хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:

- Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 4-6 дугаар зүйл, 8-13 дугаар зүйл, 16-20 дугаар зүйл /2019 он/
- Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.5, 16 дугаар зүйл /2019 он/
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт /2020/
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль; /2020 он/
- Коронавируст халвар /КОВИД19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.26,
- 2016 оны 19 дүгээр тогтоол “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” ;
- 2016 оны 45 дугаар тогтоол “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр” ;
- 2020 оны 52 дугаар тогтоол “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг;
- 2001 оны 57 дугаар тогтоол “Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”;
- 2020 оны 24 дүгээр тогтоол “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”;
- 2019 оны 156 дугаар тогтоолоор баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр”;
- 2020 оны 113 дугаар тогтоолоор баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”;
- 2016 оны 138 дугаар тогтоолоор батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас санхүүжүүлэх хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах түр журам”;
- Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 02 дугаар тогтоол “Орон нутагт жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх дэд хөтөлбөр”

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул нэгтгэн удирдаж, ахлах аудитор Я.Зориг, аудитор С.Энхбаатар, Ч.Удвалноров, М.Ганбилэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Аудитын төлөвлөлтийн өмнөх шатны судалгааны ажлыг аудитын багийн ахлах байгууллага /Дорнод/, гишүүн /Говьсүмбэр/ байгууллагууд 2022 оны 06 дугаар сарын 15-ны дотор гүйцэтгэж, төлөвлөгөөг 2022 оны 07 дугаар сарын 01-ний дотор батлуулж, талбарын ажлыг 2022 оны 07 дугаар сарын 02-ны өдрөөс 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл гүйцэтгэлээ.

Аудитын дэд тайланг 2022 оны 10 дугаар 30-ны өдрийн дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газраас хүлээн авч, нэгдсэн тайланг боловсруулан Монгол Улсын Ерөнхий аудиторт 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор танилцуулж, баталгаажуулав.

Аудитыг гүйцэтгэх хугацаанд орон нутагт “Төрийн хяналт-Аудит 100” арга хэмжээний зохион байгуулалтын ажлууд давхцаж гүйцэтгэлийн үе шатны ажилбарын хугацаа давчуу, мөн ЖДҮГ-аас аудиттай холбоотой мэдээ, тайлан, баримт материалыг гаргуулан авахад ҮАГ-аар дамжуулан албан бичгээр харьцаж байсан нь аудитын хугацаанд хүндрэл учруулж байлаа.

Үндсэн мэдээлэл

Жижиг, дунд, үйлдвэр, үйлчилгээг дэмжих чиглэлээр Засгийн газар, аймаг, орон нутгийн зүгээс үндэсний болон орон нутгийн хөтөлбөр, дэд хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна.

Монгол Улсад жижиг, дунд үйлдвэрийг дэмжих чиглэлээр Жижиг, дунд, үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, хяналт тавих журам болон бусад хууль тогтоомжоор зохицуулж байна.

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6-11.7, ЗГ-ын 2020 оны 113 дугаар тогтоол “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, хяналт тавих журам”-ын 3.2 дахь хэсэгт ЖДҮ-ийн зээлд хамрагдах ААН-ийн ангилал, борлуулалтын орлогод тавигдах шаардлага, зээлийн хэлбэр, ажилтны тоо, 1 удаа олгох зээлийн хэмжээ зэргийг заасан байна.

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.7-д:

- Бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид зээлийг Сангаас шууд,
- Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид банкаар дамжуулж олгоно. гэж заасан.

Ангилал	Ажилтны тоо	Борлуулалтын орлого	Санхүүгийн дэмжлэг
Бичил	10 хүртэл	300.0 хүртэл сая	300.0 сая төгрөг хүртэл
Жижиг	10-50 хүртэл	300.0-1000.0 хүртэл	1.0 тэрбум төгрөг хүртэл
Дунд	50-200	1000.0-2500.0 хүртэл	2.5 тэрбум төгрөг хүртэл

ЗГ-ын 2020 оны 113 дугаар тогтоол “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.2-т борлуулалтын орлогоос хамааруулан дараах байдлаар санхүүжүүлнэ.

№	Ангилал	Зээл олгох хэлбэр	Борлуулалтын орлого /төгрөг/	Зээлийн дээд хэмжээ /төгрөг/
1	Бичил	Сангаас шууд олгох	0-100,0 сая хүртэл	100,0 сая хүртэл
			100,0-200,0 сая хүртэл	200,0 сая хүртэл
			200,0-300,0 сая хүртэл	300,0 сая хүртэл
2	Жижиг	Банкаар дамжуулан олгох	300,0 саяас-1,0 тэрбум хүртэл	1,0 тэрбум хүртэл
3	Дунд		1,0-2,5 тэрбум хүртэл	2,5 тэрбум хүртэл

ХХААХҮС-ын 2019 оны А-41, 2020 оны А-131 дүгээр тушаалаар Дорнод аймагт 2019-2020 онд ЖДҮХС-аас нийт 2.0 тэрбум төгрөгийн зээл олгох эрх олгохоор баталсан байна.

ЖДҮХС-аас 2019 онд Дорнод аймагт 12 аж ахуйн нэгж, иргэнд 825.0 сая төгрөг, Говьсүмбэр аймагт 10 аж ахуйн нэгж, иргэнд 691.0 сая төгрөг, 2020 онд Дорнод аймагт 8 аж ахуйн нэгжид 422.1 сая төгрөг, Говьсүмбэр аймагт 6 аж ахуй нэгжид 448.0 сая төгрөг, нийт 2,386.1 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг тус тус олгосон байна.

Дорнод аймгийн хувьд орон нутагт жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангах зорилгоор 2009 оноос эхлэн Хас банкинд 233.2 сая төгрөгийг байршуулан зээл олгож эхэлсэн байна.

Мөн 2010 оны 4 дүгээр сараас эхлэн 350.0 сая төгрөгийг нэмэлтээр байршуулж, зээл олголт үргэлжилснээр 2021 оны 1 дүгээр сарын байдлаар нийт 156 иргэн, аж ахуйн нэгжид 2.8 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.

БҮЛЭГ 1

Орон нутагт ЖДҮ-г хөгжүүлэх эрх зүйн орчин хангалттай бүрдээгүйгээс кластераар хөгжүүлэх бодлого, төрийн зарим байгууллагын бүтэц чиг үүрэг, санхүүжилтийн төлөвлөлт зэрэг асуудлууд оновчтой тодорхойлогдоогүй байна.

1.1. Орон нутагт ЖДҮ-г хөгжүүлэх эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй байна.

1.1.1. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих дэд хөтөлбөр хууль журамд заасны дагуу батлагдсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 156 дугаар тогтоолоор “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг баталсан байна. Уг хөтөлбөрт орон нутагт жижиг, дунд үйлдвэрийг дэмжих дэд хөтөлбөрийг батлах талаар тусгаагүй байна.

Харин Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3-т “Тухайн нутаг дэвсгэрт жижиг, дунд үйлдвэрийг дэмжих орон нутгийн хөтөлбөр батлах, хэрэгжилтэд хяналт тавих” гэж зааснаар Дорнод аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 02 дугаар тогтоолоор “Орон нутагт жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийг баталсан байна.

1.1.2. Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг кластераар хөгжүүлэх бодлого, чиглэл эрх зүйн баримт бичгүүдэд бүрэн судалгаатай тусгагдаагүй байна.

Монгол Улсад 2019 онд шинэчлэн батлагдсан Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд анх удаа жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг нэгдэн нийлж, төрөлжин кластер хэлбэрээр дэмжих бодлогыг гол зорилго болгож хуульд тусгасан байна. Уг хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-т “Тухайн шатны Засаг дарга жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг кластераар хөгжүүлэх тухай саналаа боловсруулж, дээд шатны эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ.” гэснийг үндэслэн 2020 оны 01 дүгээр сарын 08-ны ХХААХҮ-ийн Сайдын 01/87 дугаар тоот албан бичгээр Монгол Улсын Засгийн газрын тогтоолд тусгах кластераар бүсчлэн хөгжүүлэх төлөвлөгөөний саналаа түүхий эдийн нөөц, эрэлт, хэрэгцээ зэрэгт тулгуурлан боловсруулж 2020 оны 01 дүгээр сарын 25-ны дотор ирүүлэхийг заасан байна.

Энэ заалтын дагуу 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр аймгийн ЗДТГ-аас Монгол Улсын Засгийн газрын тогтоолд тусгах кластераар бүсчлэн хөгжүүлэх төлөвлөгөөний саналыг хүргүүлсэн байна. Хүргүүлсэн санал нь бодитой тооцоо судалгаанд үндэслээгүй, эдийн засгийн үр нөлөөг тооцоолж орон нутгийн хэтийн төлөвлөгөөтэй нийцэхгүй буюу оновчтой тусгагдаагүй байна.

Харин Дорнод аймгийн 2016-2025 оны хөгжлийн хэтийн зорилтын бодлогын чиглэл 5(тэргүүлэх чиглэл)-д “Уул уурхайн боловсруулах болон барилгын материалын үйлдвэрлэлийг кластерийн хандлагаар хөгжүүлж, бүтээгдэхүүнээ дотоод, гадаад зах зээлд нийлүүлнэ.”, Дорнод аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 5.9.3-д “Орон нутгийн түүхий эдэд тулгуурласан брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлж, борлуулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр кластерын мэдлэг олгох сургалтыг бизнес эрхлэгчдэд зохион байгуулна.” гэсэн заалтуудыг тусгасан боловч суурь судалгаанд үндэслэж бүрэн тусгагдаагүй байна. Өөрөөр хэлбэл, SMART зарчим буюу тодорхой, нарийвчилсан, хэмжигдэхүйц, хүрч чадахуйц, чухал, цаг

хугацаатай байхаар кластерийн зорилгоо тодорхойлж чадаагүй байна. Тодруулбал, хэн, хэзээ, ямар зохион байгуулалтаар, хэрхэн хэрэгжүүлэх талаар ЖДҮ хариуцсан төрийн байгууллагууд болоод ЖДҮ эрхлэгч нарын кластерийн үр ашиг, үр нөлөөний талаарх ойлголт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1¹, 9 дүгээр зүйлийн 9.4², 15 дугаар зүйлийн 15.1.2³, Засгийн газрын 2019 оны 156 дугаар тогтоолын хавсралт "ЖДҮ-г дэмжих үндэсний хөтөлбөр"-ийн 4 дүгээр зүйлийн 4.5.8⁴ дахь заалтуудыг зөрчсөн байна.

Жижиг, дунд үйлдвэрлэл (ЖДҮ)-ийг эрчимтэй дэмжиж, бодлогоор хөгжүүлэх нь дэлхийн улс орнуудын эдийн засгийн нэн тэргүүний зорилтуудын нэг билээ. ЖДҮ-ийг хөгжүүлэх нь ядуурал, ажилгүйдлийг бууруулахын зэрэгцээ эдийн засгийн өсөлтөд чухал үүрэг гүйцэтгэдэг. ЖДҮ-ийг хөгжүүлснээр орлогын тэгш бус хуваарилалтыг бууруулах, нийгмийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлэх, хувийн секторын хөгжлийг хангахад чухал хувь нэмэр үзүүлдэг.

Тухайлбал, Дорнод аймгийн ЖДҮ-ийн өнөөгийн байдалд SWOT шинжилгээ хийв.

Хүснэгт 1. "Дорнод аймгийн ЖДҮ-ийн өнөөгийн байдалд хийсэн SWOT шинжилгээ"

Давуу тал	Сул тал
- Нэг хүнд ногдох ДНБ өндөр (2020 оны байдлаар Улсын дунджаас 18,3 хувиар бага, зүүн бүсийн дунджаас 22,5 хувиар өндөр, 2020 онд 12,434.6 мянган төгрөг) - Эдийн засгийн хөгжлийн түвшин өрсөлдөх чадвараар өндөр - Ажлын байрны хүрэлцээ сайн - ДНБ болон ДНБ-ий өсөлт - Харилцаа холбооны технологи харьцангуй сайн хөгжсөн	- Орон нутгийн зах зээлийн багтаамж бага, хүн амын худалдан авах чадвар сул байдал - Санхүү, хөрөнгө оруулалтын хүрээ хязгаарлагдмал - Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа тогтворжоогүй, бие даах чадвар сул - Аж ахуйн нэгжүүдийн менежментийн хөгжил сул - Орон нутаг дахь аж ахуй нэгжүүдийн хувьд санхүүгийн эх үүсвэр харьцангуй дутмаг - Барьцаа хөрөнгийн үнэлгээ зах зээлийн үнэлгээнээс доогуур хийгддэг - Ажиллах хүчний үр чадвар сул⁵ - Ажиллах хүчний оролцооны түвшин сул⁶
Боломж	Аюул, занал
- Эрчим хүчний үнэ улсын дунджаас бага, төвийн нэгдсэн сүлжээнд холбогдсон нь үйлдвэрлэлийн хөгжилд тустай⁷ - Зам тээврийн хөгжлийн түвшин харьцангуй сайн учир орон нутгийн үйлдвэрүүд төвлөрсөн зах зээлд бүтээгдэхүүнээ нийлүүлэх харьцангуй боломжтой. - Засаглалын хувьд ил тод байдал бусад аймгуудтай харьцуулахад тогтвортой.	- Төрийн байгууллагын үйлчилгээний шат дамжлага их - Хэрэгжүүлэгч байгууллагын эрх, үүрэг нь харьцангуй хязгаарлагдмал - Орон нутгийн хяналт, шалгалтын байгууллагуудаас давхардсан хяналт шалгалт их - Чанаргүй зээлийн үлдэгдэл өндөр - 2020 оны байдлаар чанаргүй зээлийн хувь 2,2 (нийт зээлийн үлдэгдэлд эзлэх хувь)⁸ - Албан бус эдийн засгийн түвшин өндөр

Эх сурвалж: Аудиторын хийсэн шинжилгээ

Уг шинжилгээнд тулгуурлаад дараах байдлаар ЖДҮ-ийн бизнес эрхлэгчдийг дэмжиж кластераар хөгжүүлэх чиглэлийг үндэслэлтэйгээр төлөвлөж болох юм. Өөрөөр хэлбэл, Эдийн засгийн хөгжлийн түвшин өрсөлдөх чадвараар өндөр байдал нь Дорнод аймгийн хувьд маш том давуу тал бөгөөд үүнд тулгуурлаад ЖДҮ-ийн менежмент болон санхүүгийн дутмаг байдлыг бууруулах стратеги авч

¹ Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг кластераар хөгжүүлэхэд төрөөс дараах дэмжлэгийг үзүүлнэ:

² Орон нутагт кластерын хэлбэрээр үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжийн төсөл нь энэ хуулийн 15.1.2-т заасан чиглэлд хамаарч байвал төрөөс тэргүүн ээлжинд дэмжинэ.

³ орон нутгийн түүхий эдийн нөөц, эрэлт, хэрэгцээ, энэ хуулийн 18.3-т заасан саналыг харгалзан кластераар бүсчлэн хөгжүүлэх чиглэлийг батлах;

⁴ жижиг, дунд үйлдвэрийн кластер байгуулах, нэгдэх санал санаачилгыг дэмжиж, кластерт бүртгэлтэй аж ахуйн нэгж, иргэнд нэн тэргүүнд хөнгөлөлт олгох.

⁵ Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал-Түүвэр судалгааны үр дүн

⁶ Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал-Түүвэр судалгааны үр дүн

⁷ Улсын дундажаас төг/кВт.ц (155,90-122,0) 33,9-өөр бага байна. Эрчим хүчний зохицуулах хороо - <https://erc.gov.mn/web/mn/>

⁸ Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан 2020, хуудас 67.

хэрэгжүүлэх, ЖДҮ эрхлэгчдийн хувьд маш чухал асуудал болох дэд бүтцийн үзүүлэлтүүд боломжийн нөхцөлтэй байгаа нь үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд тохиромжтой. Тэгэхээр өөрт байгаа давуу тал дээр тулгуурлаад сул талаа бууруулах, боломж дээрээ тулгуурлаад аюул, заналаа багасгах стратегиудыг авч хэрэгжүүлбэл, Дорнод аймгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлээд зогсохгүй ЖДҮ эрхлэгчдээ дэмжих боломжтой суурь судалгааг үндэслэлтэй хийж болох юм.

“Хүснэгт 2. “Дотоодын нийт бүтээгдэхүүний салбарын бүтэц, хувиар”

д/д	Салбар	Зүүн бүс		Дорнод	
		2019 он	2020 он	2019 он	2020 он
1	ДНБ, зах зээлийн үнээр	100	100	100	100
2	Хөдөө аж ахуй	34.6	39.16	21.4	27.97
2.1	Газар тариалан	2.5	2.45	2	2.21
2.2	Мал аж ахуй	31.8	36.63	19.3	25.69
2.3	ХАА-н бусад	0.4	0.08	0.1	0.07
3	Үйлдвэрлэл	45	37.29	60.6	50.6
3.1	Уул уурхай, олборлох	32.9	23.23	51.2	37.73
3.2	Боловсруулах	9.4	10.71	5.4	7.27
3.3	Цахилгаан, хий, уур хангамж, усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент, цэвэрлэх үйл ажиллагаа	2	2.37	3.2	4.04
3.4	Барилга	0.7	0.99	0.8	1.56
4	Үйлчилгээ	20.5	23.54	18.1	21.43
4.1	Худалдаа, зочид буудал, зоогийн газар	3.2	3.85	3.3	4.32
4.2	Тээвэр, мэдээлэл, холбоо	1.2	0.71	1.4	0.83
4.3	Санхүү, бизнесийн бусад үйл ажиллагаа	4.9	6.16	4.2	5.6
4.4	Бусад үйлчилгээ	11.2	12.82	9.1	10.68

Эх сурвалж: ҮСХ-ны нэгдсэн сайт www.1212.mn

1.1.3. Хууль, дүрэм журамд төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүрэг оновчтой тодорхойлогдсон боловч жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвийн бүтэц, чиг үүргийг тодорхойлсон заалт байхгүй байна.

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 5 дугаар бүлэгт төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүргийг тодорхойлсон боловч хууль, журамд жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвийн бүтэц, чиг үүргийг тодорхойлсон зүйл заалт байхгүй байна. “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв” ОНӨААТҮГ-ыг Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 156 дугаар тогтоолоор баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн 2 дугаар үе шат гэж үзэн Дорнод аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дугаар 90 тогтоолоор байгуулсан байна.

Дорнод аймгийн Засаг даргын 2022 сарын 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/12 дугаар захирамжаар “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв” ОНӨААТҮГ-ын бүтэц, орон тоо, цалингийн сүлжээг шинэчлэн баталсан байна. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвийн бүтэц, чиг үүргийг хуулиар зохицуулаагүй байгаа нь төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, үйл ажиллагаа нь хууль, дүрэм журмын дагуу явагдахгүй байх сөрөг нөлөөтэй байна. Энэ талаар холбогдох хууль, дүрэм журамд тусгаж өгснөөр төрийн байгууллагууд болон жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн уялдаа холбоо сайжирч, ЖДҮ-ийг дэмжих төвийн үйл ажиллагаа үр дүнтэй болох юм.

1.1.4. Төслийг ил тод, нээлттэй сонгон шалгаруулах орчин бүрдсэн байна.

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5-д “Сангаас хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журмыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 16.7-д заасны дагуу Засгийн газар батална” гэж заасан байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 4

дүгээр сарын 19-ний өдрийн А-119 дүгээр тушаал “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журам”, Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 25-ны 113 дугаар тогтоол “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих тухай журам”-д төсөлд тавигдах шаардлага, бүрдүүлэх материал, ил тод байдал зэргийг тусгасан байгаа нь төслийг ил тод, нээлттэй сонгон шалгаруулах орчныг бүрдүүлсэн байна.

1.1.5. Төрөөс баримтлах бодлого чиглэл дэд хөтөлбөрт бүрэн тусгагдаагүй байна.

Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 15 дугаар зүйлд Төрөөс жижиг, дунд үйлдвэрийг дэмжих талаар 4 баримтлах бодлого, үндсэн чиглэлийг заасан боловч аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 01 сарын 10-ны өдрийн 02 дугаар тогтоолоор “Орон нутагт жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийг батлахдаа хуульд заасан төрөөс баримтлах бодлого, үндсэн чиглэлийг бүрэн тусгаагүй байна. Тухайлбал: Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 15 дугаар зүйлд дараах 4 бодлого, үндсэн чиглэлийг тусгасан байна. Үүнд:

1. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн бизнесийн шинэчлэл, шинээр бизнес эрхлэх болон бүтээлч үйл ажиллагааг дэмжих
2. Жижиг, дунд үйлдвэрийн менежментийн нөөц, бизнес эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх замаар жижиг, дунд үйлдвэрийн менежментийн үндэс суурийг бэхжүүлэх
3. Жижиг, дунд үйлдвэрийн менежментийн тогтвортой байдлыг хангах, бизнесийг хувирган өөрчлөх боломжийг бүрдүүлэх замаар жижиг, дунд үйлдвэрийн эдийн засаг, нийгмийн өөрчлөлтөд зохицох чадварыг нэмэгдүүлэх
4. Жижиг, дунд үйлдвэрийг санхүүгийн талаар дэмжих, тэдгээрийн өөрийн хөрөнгийн хангалттай байдлыг сайжруулах гэж заасан байна.

“Орон нутагт жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих дэд хөтөлбөр”-т төрөөс жижиг, дунд үйлдвэрийг дэмжих бодлого, үндсэн чиглэлийг бүрэн тусгаж өгөөгүй нь энэ чиглэлээр төрийн бодлого, шийдвэр хэрэгжихгүй байх, орон нутагт ЖДҮ хөгжихгүй байх сөрөг үр дагавартай байна.

Иймд ЖДҮ-ийг хөгжүүлж, дэмжих талаар төрөөс баримтлах бодлого, чиглэлийн хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай байна.

1.2. Аймгуудад олгох ЖДҮ-ийн санхүүжилтийг төлөвлөхдөө бодит хэрэгцээ, шаардлага, тооцоо судалгаанд үндэслээгүй байна.

1.2.1. Аймгуудад олгох зээлийн төлөвлөлтийг бодит хэрэгцээ, шаардлага, тооцоо судалгаанд үндэслэдэггүй байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А-119 дүгээр тушаалын хавсралт “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журам”-ын дагуу “Хөнгөлөлттэй зээлийн ерөнхий нөхцөл батлах тухай” сайдын тушаалаар Говьсүмбэр аймаг 500.0 сая, бусад аймгуудад 1.0 тэрбум төгрөгийг зээлийн ерөнхий нөхцөлийн хүрээнд тусгаж, Дорнод аймгийн хувьд 12 аж ахуй нэгжид 825.0 сая төгрөгийн зээл олгогдсон байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолын хавсралт “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу “Хөнгөлөлттэй зээлийн ерөнхий нөхцөл батлах тухай” сайдын тушаалаар

Говьсүмбэр аймаг 500.0 сая, бусад аймгуудад 1.0 тэрбум төгрөгийг зээлийн ерөнхий нөхцөлийн хүрээнд тусгасан боловч эх үүсвэр бүрдээгүй учир 2020 оны 11 дүгээр сарын 03-ны А-357 дугаар тушаалаар өмнөх тушаал буюу ХХААХҮ-ийн Сайдын 2020 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн А-131 дүгээр тушаалд өөрчлөлт оруулан аймаг тус бүрт 500.0 сая төгрөгийг баталж, Дорнод аймгийн хувьд 8 аж ахуй нэгжид 422.1 сая төгрөгийн зээл олгогдсон байна.

Уг зээл нь аймгуудын өрсөлдөх чадвар болон өөр бусад хүчин зүйлүүдээс огт хамааралгүй сайдын тушаалаар хувь тэнцүүлэн олгосон байна. Өөрөөр хэлбэл, аймгийн хүн ам, нийслэлээс алслагдсан байдал, ард иргэдийн худалдан авах чадвар, ажилгүйдлийн түвшин, ядуурал, үйлдвэрлэл эрхлэхэд таатай буюу хязгаарлагч хүчин зүйл багатай эсэхэд үндэслэн тооцоолоогүй байна.

Хүснэгт 3. “Дорнод аймгийн эдийн засгийн үзүүлэлтүүд”

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019 он	2020 он
1	Хүн амын тоо	мян.хүн	82.1	83.1
2	Ажилгүйдлийн түвшин	хувь	20.9	14.0
3	Ядуурал	хувь	42.5 ⁹ (2018 он)	37.1 ¹⁰ (2020 он)
4	Нийслэлээс алслагдсан зай	км	656	

Эх сурвалж: ҮСХ-ны нэгдсэн сайт www.1212.mn

Тухайлбал, аймгуудын өрсөлдөх чадварын ерөнхий үнэлгээгээр 2020 онд Дорнод аймгийн хувьд 73,4 буюу 21 аймгаас 8 дугаарт эрэмбэлэгдсэн байна. Тасралтгүй сүүлийн 9 жил боловсруулагдаж буй уг тайлан¹¹-д өнгөрсөн хугацаанд Дорнод аймгийн хувьд бизнес, үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих /төр хувийн хэвшлийн түншлэл, шударга өрсөлдөөн бүхий орчин/ гэсэн үзүүлэлт шийдвэрлэгдэхгүй 8 жилийн турш дурдагдсаар байгаа бөгөөд энэ нь аймгийн хөгжлөөс хойш татсан хэвээр байна.

1.2.2. Төслийн шалгаруулалтын үйл ажиллагааг бүрэн дууссанаар санхүүжүүлэх үйл ажиллагаа цаг тухай бүрт хуваарилагдсан байна.

Дорнод аймгийн ХХААГ-аас Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд зориулан хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж 2019 онд 5 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн төслийг хүлээн авч 12 дугаар сарын 20-ныг хүртэл төслийн сонгон шалгаруулалтын бүх үе шат, 2020 онд 4 дүгээр сарын 20-ны өдрөөс 12 дугаар сарын 25 хүртэл төслийн бүх үе шат болон санхүүжилт олгох үйл явц хийгдсэн байна.

Төслийн зээл олгогдох хугацаа нь журмын дагуу хийгдэхээс гадна дараах 2 нөхцөлөөр хойшлогддог байна. Үүнд:

1. Төслийн сонгон шалгаруулалтын нарийвчилсан шатанд ЖДҮГ-аас орон нутагт ирж танилцахтай холбоотойгоор хүлээгддэг.
2. Төслийн сонгон шалгаруулалт хийгдэж дуусаад санхүүжилт олгох шатанд барьцаа хөрөнгө дутагдалтай, үнэлгээ бага байх зэргийг судлахтай холбоотойгоор мөн хүлээгддэг байна.

Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолын хавсралт “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-д дараах байдлаар заасан байна.

⁹ Дорнод аймаг нь 2018 оны байдлаар ядуурлын түвшин 42,5% байгаа нь улсын дунджаас 14,1 хувиар, зүүн бүсийн дунджаас 5,1 хувиар илүү байна.⁹

¹⁰ Дорнод аймаг нь 2020 оны байдлаар ядуурлын түвшин 37,1% байгаа нь улсын дунджаас 9,3 хувиар, зүүн бүсийн дунджаас 3,8 хувиар илүү байна.¹⁰

¹¹ Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан 2020

Хүснэгт 4. "Зээл олгох журмын сангаар болон банкаар дамжуулан олгох зээлд зарцуулах хугацааны харьцуулалт"

Заалтууд	Сангаас шууд зээл олгох	Банкаар дамжуулан зээл олгох
10.5.	Хуанлийн 30 хоног	
11.3.	Ирсэн төслийн тоог*нэг төслийг үнэлэхэд зарцуулах хоног 1-212 (урьдчилсан судалгаагаар)	
11.5.7.	Эрэмбэлсэн жагсаалтыг ЖДҮГ-г хүргүүлэх хугацаа ажлын 5 хоног	
12.2.3.		Хүлээн авах хугацаа 14 + судлах хугацаа 30
12.2.4.		Батлан даалтын сантай холбоотойгоор 14 хоног
Барьцаа хөрөнгийн үнэлгээ хийх хугацаа	Хамгийн багадаа ойролцоогоор 3 сарын хугацаанд төслийг судлан санхүүжүүлдэг байна.	Хамгийн багадаа ойролцоогоор 5-6 сарын хугацаанд төслийг судлан санхүүжүүлдэг байна.

Эх сурвалж: Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолын хавсралт "Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"

Уг журмаар төсөл олон нийтэд зарлагдаж хүлээн авахаас эхлээд санхүүжилт олгогдох хүртэлх төслийн сонгон шалгаруулалт нийтдээ 3-6 сарын хугацааг зарцуулахаар байна.

1.2.3. Бичил, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн үйл ажиллагаанд тавьж буй орлогын хязгаарлалт нь бодитой байна.

Дорнод аймгийн хэмжээнд 2019, 2020 онд зээлд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдээс авсан судалгаанд оролцогчдоос ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагаанд тавьж буй борлуулалтын орлогын хязгаар нь бизнесийн үйл ажиллагааны орлоготой нийцэж байна гэсэн үр дүн гарсан.

"Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль"-д дараах аж ахуйн нэгжийг ЖДҮ эрхлэгчид гэж заасан байна. Үүнд:

- Бичил: Ажилтны тоо: 1-9, Борлуулалтын орлого: 300.0 сая төгрөг хүртэл
- Жижиг: Ажилтны тоо: 10-49, Борлуулалтын орлого: 300.0-1.0 тэрбум төгрөг хүртэл
- Дунд: Ажилтны тоо: 50-119, Борлуулалтын орлого: 1.0-2.5 тэрбум төгрөг хүртэл гэж хуульд заасан байна.

Хүснэгт 5. "Аж ахуйн нэгжүүдийн ажиллагчдын ангилал"

Ажилчдын тооны бүлэг	Аймаг сум	2019-II		2020-II	
		Тоо	Хувь	Тоо	Хувь
Бүгд	Улсын дүн	88893	100	96388	100
	Зүүн бүс	3549	3.99%	3832	3.98%
	Дорнод	1603	1.8%	1731	1.80%
1-9	Улсын дүн	77018	86.64%	83527	86.66%
	Зүүн бүс	2943	3.31%	3145	3.26%
	Дорнод	1350	1.52%	1450	1.50%
10-49	Улсын дүн	9395	10.57%	10407	10.80%
	Зүүн бүс	505	0.57%	583	0.60%
	Дорнод	207	0.23%	233	0.24%
50+	Улсын дүн	2480	2.79%	2454	2.55%
	Зүүн бүс	101	0.11%	104	0.11%
	Дорнод	46	0.05%	48	0.05%

Эх сурвалж: ҮСХ-ны нэгдсэн сайт www.1212.mn

Дорнод аймгийн хувьд 2020 оны байдлаар аж ахуйн нэгжүүдийн ажиллагчдын ангиллаар 1731 аж ахуйн нэгж буюу зүүн бүсийн аж ахуйн нэгжүүдийн 45.2 хувийг эзэлж байна. Харин 1-9 ажилтантай 1450, 10-49 ажилтантай 233, 50-аас дээш ажилтантай 48 аж ахуйн нэгжүүд тус тус байна.

¹² Дорнод аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Жижиг, дунд үйлдвэр, хоршоо ахуйн үйлчилгээ хариуцсан мэргэжилтний ярилцлагын тэмдэглэл.

ЖДҮ эрхлэгчид 2019, 2020 онд 20.0-135.0 сая төгрөгийн зээл авсан байна. Судалгааны үр дүнд 2019, 2020 онд зээлд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдэд борлуулалтын орлогын хамгийн доод буюу 300.0 сая төгрөгийн хязгаарт ч хүрээгүй байна.

1.2.4. Зээлийг арилжааны банкны журмаар олгох нь төрөөс баримталж буй бодлого, шийдвэртэй бүрэн нийцэхгүй байна.

Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А-119 “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журам”-ын дагуу Дорнод аймгийн хэмжээнд 2019 онд нийт 75 төсөл зарлагдсан хугацаанд ирснээс дэд хорооны хурлаар журмын 1.4 дэх заалтаар 18 төсөл хасагдаж, 57 төслийг хэлэлцүүлсэн. Үүнээс 14 төсөл 1 тэрбум төгрөгийн зээлд багтан эрэмбэлэгдэж, үүнээс банкны шаардлага хангаагүй 3 төсөл хасагдсанаар эрэмбийн доороос 2 төсөл судлагдах боломжтой болж, 1 төсөл санхүүжилт хангалтгүй гэж үзэж банканд төслөө судлуулаагүй нийт 12 төсөл санхүүжилт авсан байна.

Харин 2020 онд Монгол Улсын Засгийн газрын 113 дугаар тогтоолын хавсралт “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу нийт 32 төслийг хүлээн авч журмын 1.4¹³ дэх заалтаар 2 төсөл, 5.9 дэх заалтаар 9 төсөл хасагдаж, 21 төслийг нарийвчилсан хяналтад шилжүүлсэн.

Арилжааны банкны журмаар олгосон зээл нь Монгол банкны мэдээллийн санд бүртгэгддэг, зээлийн эргэн төлөлт сайн хийгдэж байгаа давуу талтай байна. Харин арилжааны банкаар дамжуулан олгож буй зээл нь сангаас шууд олгож буй зээлээс 2019 оны хувьд журмын 14 дүгээр зүйлийн 14.3.4¹⁴ болон 14.3.5¹⁵-д заасанчлан даруй 47 хоногт, 2020 оны 12 дугаар зүйлийн 12.2.3¹⁶ болон 12.2.4¹⁷-д зааснаар 61 хоногт судлах хугацаагаар тус тус илүү сунгагдахаар заагдсан байна. Энэ мэтчилэн зээлийг арилжааны банкаар дамжуулах нь ЖДҮ эрхлэгчдийн хувьд шат дамжлага ихсэх, зээлийн шалгуур өндөр болох, барьцаа хөрөнгө хүрэхгүй байдаг зэрэг нь төрөөс баримталж буй бодлого шийдвэртэй нийцэхгүй байна.

Аймгийн ЗДТГ-аас олгож буй зээлийн хувьд 2009, 2010 онд нийт 583.1 сая төгрөгийг Хас банкинд байршуулан жил бүрийн зээлийн эргэн төлөлтөөс орж ирсэн орлогоос ЖДҮ эрхлэгчдэд зээл олгож ирсэн байна. ТБОНӨХБАҮХАТХ-д зааснаар нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэх нөхцөл үүссэн байхад жил бүр зөвхөн Хас банкаар дамжуулан зээл олгож байгаа нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.2¹⁸, 17.1¹⁹-д заасныг баримтлаагүйтэй холбоотой байна.

¹³ ЖДҮҮЭ-д дараах тохиолдолд зээл олгохгүй: 1.4.1-1.4.11.

¹⁴ Банк жагсаалтаар хүргүүлсэн төслийг хуанлийн 30 хоногт багтаан судалж, шаардлага хангасан төслийн шийдвэрийг банкны зээлийн хорооны шийдвэр, зээлийн гэрээ, барьцааны гэрээ болон нэхэмжлэлийн хамт баталгаажуулан санд хүргүүлнэ.

¹⁵ Банк барьцаа хөрөнгийн дутагдалтай иргэн, аж ахуйн нэгжийн жагсаалтыг зээлийн хорооны шийдвэрийн хамт зээлийн батлан даалтын сан 14 хоногт багтаан батлан даалт гаргах эсэх асуудлаар шийдвэр гаргана. Банк зээлийн батлан даалтын сангийн шийдвэрийг гарсан даруйд баталгаажуулан Санд хүргүүлнэ.

¹⁶ Банк жагсаалтаар хүргүүлсэн төслийн зээлийн судалгааны материалыг 14 хоногийн дотор төсөл хэрэгжүүлэгчээс бүрэн хүлээн авч, түүнээс хойш хуанлийн 30 хоногт багтаан судалж, шаардлага хангасан төслийн жагсаалт банкны зээлийн хорооны шийдвэр, зээлийн гэрээ, барьцаа гэрээ болон нэхэмжлэлийн хамт баталгаажуулан жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ;

¹⁷ Банк барьцаа хөрөнгийн дутагдалтай иргэн, аж ахуйн нэгжийн жагсаалтыг зээлийн хорооны шийдвэрийн хамт Зээлийн батлан даалтын санд хүргүүлэх ба зээлийн батлан даалтын сан 14 хоногт багтаан батлан даалт гаргах эсэх асуудлаар шийдвэр гаргана. Банк зээлийн батлан даалтын сангийн шийдвэрийг гарсан даруйд баталгаажуулан жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ;

¹⁸ Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ.

БҮЛЭГ 2

ЖДҮХС болон аймгийн ЖДҮ-ийн зарим зээлүүд зориулалт бусаар үр дүнгүй зарцуулагдсан байна.

2.1. Дэд хороо журмын дагуу байгуулагдсан ч чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

2.1.1. Төсөл сонгон шалгаруулах дэд хороог журамд заасны дагуу 8 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Аймгийн төсөл сонгон шалгаруулах дэд хороог Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 4 дүгээр сарын 19-ний А-119 дүгээр тушаалаар “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журам”, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 25-ны 113 дугаар тогтоолоор “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 6 дугаар зүйлийн 6.8²⁰ дахь заалтын дагуу аймгийн Засаг даргын 2019 оны 5 дугаар сарын 20-ны А/248, 2020 оны 5 дугаар сарын 26-ны А/320 дугаар захирамжаар тус тус 8 хүний бүрэлдэхүүнтэйгээр төсөл сонгон шалгаруулах дэд хороог байгуулсан байна.

Төсөл сонгон шалгаруулах дэд хороог журмын 6 дугаар зүйлийн 6.2²¹-д заасны дагуу хорооны бүрэлдэхүүнд орон нутгийн төрийн байгууллагын төлөөлөл 3, 6.4²²-т заасны дагуу төрийн бус байгууллагын төлөөлөл 4, хорооны нарийн бичгийн даргаар аймгийн ХХААГ-ын ЖДҮ хариуцсан мэргэжилтэн саналын эрхгүй оролцсон байна.

2.1.2. Аймгаас олгож буй ЖДҮ-ийн зээлээр ерөнхий чиглэлд тусгагдаагүй 3 төсөлд зээл олгосон байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А-146 дугаар тушаал, 2020 оны А-131 дүгээр тушаалаар жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 2019-2020 онд урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох салбар, чиглэлийг баталсан байна.

ЖДҮХС-гийн санхүүжилтээр 2019, 2020 онд хэрэгжсэн төслүүд нь ХХААХҮС-ын баталсан салбар, чиглэлийн хүрээнд олгогдсон байна.

Тухайлбал мал, амьтны тэжээл, мах, махан бүтээгдэхүүн, дайвар бүтээгдэхүүн, оёмол бүтээгдэхүүн, мод, модон бүтээгдэхүүн, төмс, хүнсний ногоо, туслах аж ахуй, сүү, сүүн бүтээгдэхүүн, арьс шир боловсруулах салбарт багтсан төслүүдэд санхүүжилт олгожээ. /Хүснэгт 6, 7/

Мөн 2019 онд олгосон төслүүдийн 41.6 хувь нь 5-аас доошгүй жил тасралтгүй үйл ажиллагаа явуулж байгаа, байнгын ажлын байр бий болгох, 2020 онд 50 хувь нь импортыг орлох шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлд багтсан төслүүдэд санхүүжилт олгосон байна. /Хүснэгт 6, 7/

¹⁹ Нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу зарлан мэдээлж, сонирхогч этгээдийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангана.

²⁰ Хорооны бүрэлдэхүүнийг Жижиг, дунд үйлдвэрийн асуудал, эрхэлсэн Засгийн газрын гишүүн, дэд хорооны бүрэлдэхүүнийг аймгийн Засаг дарга тус тус батална.

²¹ Дэд хорооны бүрэлдэхүүнд аймгийн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний асуудал хариуцсан байгууллагын дарга болон хөдөлмөрийн асуудал хариуцсан байгууллагын төлөөлөл орох бөгөөд нарийн бичгийн даргаар аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллагын жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн(цаашид “аймгийн мэргэжилтэн” гэх) байна.

²² Хороо, дэд хорооны бүрэлдэхүүнд 4 төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллагын төлөөлөл оруулах бөгөөд төлөөлөл нь дараах ерөнхий шаардлагыг хангасан байна.

Хүснэгт 6. “2019 онд олгосон төслүүдийн харьяалагдах салбар, чиглэл”

№	2019 он			
	Батлагдсан салбар	Төслийн тоо	Батлагдсан чиглэл	Төслийн тоо
1	Арьс, шир боловсруулах		Экспортод чиглэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх	
2	Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах		5-аас доошгүй жил тасралтгүй үйл ажиллагаа эрхэлж, байнгын ажлын байр шинээр бий болгох	5
3	Барилгын материал үйлдвэрлэх		Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн нэгдсэн тогтолцоо-Загвар хоршоо	
4	Хог хаягдал дахин боловсруулах		Баяжуулсан болон органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл	1
5	Мал, амьтны тэжээл үйлдвэрлэх	1	Инновацийн бүтээгдэхүүн нэвтрүүлэх	1
6	Ноос, ноолуур боловсруулах		Импортыг орлох шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх	1
7	Мах, махан бүтээгдэхүүн, дайвар бүтээгдэхүүн боловсруулах	2	Эрчимжсэн аж ахуй	
8	Оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэх	1	Шинэ техник, технологи нэвтрүүлэх	2
9	Мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэх	1		
10	Сав, сав баглаа боодол үйлдвэрлэх			
11	Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ боловсруулах	2		
12	Туслах аж ахуй	1		
13	Гурил, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэх	2		
14	Бусад	2		
		12		10

Эх сурвалж: ХХААГ-ын 2019 оны ЖДҮХС-ийн судалгаа, аудиторын судалгаа

Хүснэгт 7. “2020 онд олгосон төслүүдийн харьяалагдах салбар, чиглэл”

№	2020 он			
	Батлагдсан салбар	Төслийн тоо	Батлагдсан чиглэл	Төслийн тоо
1	Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах	2	Стратегийн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх	
2	Дотор мах, дайвар бүтээгдэхүүн боловсруулах	4	Импортыг орлох шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх	5
3	Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ боловсруулах	1	Экспортод чиглэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх	
4	Зоорь, хүлэмжийн аж ахуй		Баяжуулсан болон органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл	1
5	Арьс, шир боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх	1	Инновацийн бүтээгдэхүүн нэвтрүүлэх	1
6	Ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэх		Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн нэгдсэн тогтолцоо-Загвар хоршоо	1
7	Сав, баглаа боодол үйлдвэрлэх		Цахим худалдаа	
8	Аялал жуулчлалын үйлчилгээ			
9	Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, ариутгал халдваргүйжүүлэлтийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх			
		8		8


Эх сурвалж: ХХААГ-ын 2020 оны ЖДҮХС-ийн судалгаа, аудиторын судалгаа

Дээрх салбар, чиглэлд 2019-2020 онд төсөл хэрэгжээгүй байгаа нь мэргэжлийн байгууллагуудын орон нутагт ЖДҮ-г хөгжүүлэх салбаруудын судалгаа шинжилгээ дутмаг, аж ахуйн нэгжүүд тухайн чиглэлээр төсөл хэрэгжүүлэхгүй байгаатай холбоотой байна.

ЖДҮ-ийн аймгийн зээл:

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 190 дүгээр тогтоолоор “Жижиг, дунд үйлдвэрийн тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жагсаалт”-аар 10 салбар, аймгийн ЖДҮ-г хөгжүүлэх үндсэн чиглэлээр 13 салбарыг хөгжүүлэхээр баталсан байна. ЖДҮ-г хөгжүүлэх үндсэн чиглэлд багтаагүй 60.0 сая төгрөгийн санхүүжилттэй авто болон дугуй засварын 3 төсөл шалгарсан нь сонгон шалгаруулах ажлын хэсэг тогтоол, шийдвэрийг баримтлаагүй, ирүүлсэн төсөл бүрд санхүүжилт олгосонтой холбоотой байна. /Дүрслэл 1/

Дүрслэл 1. “2019-2020 онд олгосон төслүүдийн харьяалагдах салбар, чиглэл”



Эх сурвалж: АЗДТГ-ын 2019-2020 оны ЖДҮ-ийн судалгаа, аудиторын судалгаа

2.1.3. ЖДҮ-ийн төслүүдийг орон нутгийн хэрэгцээ, ач холбогдлоор эрэмбэлээгүй, зөвхөн онооны системээр шалгаруулсан байна.

ЖДҮХС-гийн зээл:

“Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 5.1²³-д төсөлд тавигдах шаардлагыг заасан байна.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан болон банкаар дамжуулан 2019, 2020 онд олгосон төслүүд нь журмын шаардлага хангасан хэдий ч төсөл сонгон шалгаруулах дэд хороо нь ирүүлсэн төслүүдийг орон нутагт хэрэгцээтэй, ач холбогдлоор нь эрэмбэлэхгүй байна.

ХХААГ-т 2019-2020 онд нийт 108 төсөл ирүүлснээс иж бүрдэл дутуу шалтгаанаар 30 төсөл хасагдаж, дэд хорооны шийдвэрээр 68 төслийг эрэмбэлж ЖДҮГ-т хүргүүлсэн байна.

Дүрслэл 2. “Төсөл сонгон шалгаруулалтын үнэлгээний явц 2019-2020 он”

- Ирүүлсэн төсөл-75 /6,063.8 сая төгрөг/
- Иж бүрдэл дутуу хасагдсан - 18 /1,664.7 сая төгрөг/
- Дэд хорооны шийдвэрээр ЖДҮГ-т хүргүүлсэн төсөл - 57 /4,399.1 сая төгрөг/
- ЖДҮХС-гаас банкаар дамжуулан олгосон төсөл - 12 /825.0 сая төгрөг/

2019

- Ирүүлсэн төсөл-33 /2,721.0 сая төгрөг/
- Иж бүрдэл дутуу хасагдсан - 12 төсөл
- Нарийвчилсан судалгаагаар хасагдсан, 70 аас доош үнэлгээ авсан - 10 төсөл
- Дэд хорооны шийдвэрээр 70-аас дээш үнэлгээ авч эрэмбэлсэн төсөл - 11 /852.3 сая төгрөг/
- ЖДҮХС-гаас олгосон төсөл - 8 /422.1 сая төгрөг/

2020

Эх сурвалж: ЖДҮХС-гийн төсөл сонгон шалгаруулах, зээл олголтын баримт 2019-2020 он

²³ Төсөл нь үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалт, хүний нөөцийн удирдлагын тухай мэдээлэл, зах зээлийн судалгаа, эдийн засгийн тооцоо, дүгнэлт, хавсралт гэсэн хэсгээс бүрдэх бөгөөд эхлэх, төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт сайжруулалт, дуусгавар болох хугацааг тодорхой заасан байна.

Төсөл шалгаруулсан байдлаас харахад дэд хорооны шийдвэрээр 68 төслийг онооны системээр эрэмбэлж ЖДҮГ-т хүргүүлсэн боловч 2019-2020 онд 20 төслийг сонгон шалгаруулж, зээл олгосон байна. Төсөл сонгон шалгаруулалтад аж ахуйн нэгж, иргэд тэнцсэн ч ЖДҮХС-гийн эх үүсвэрийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалан онооны дарааллаар эрэмбэлэгдэж, 2019 онд 45, 2020 онд 3 аж ахуйн нэгж зээлд хамрагдаагүй байна. Банкны барьцаа хөрөнгөтэй холбоотой шалгуураас шалтгаалан онооны эрэмбээр 1-р ээлжид эрэмбэлэгдсэн ч 2019 онд 3 аж ахуйн нэгж хасагдаж, эрэмбийн дарааллаар 1 аж ахуйн нэгжид зээлийг олгосон байна. Төслийн 2 дугаар ээлжид эрэмбэлэгдсэн ААН-үүдэд санхүүжилт хүрэлцэхгүй тохиолдолд дараа жилийн төслийн сонгон шалгаруулалтад дахин төсөл бичиж оролцуулах байдлаар зохион байгуулж байгаа нь ЖДҮ эрхлэгчдэд бэрхшээл үүсгэж, цаашлаад орон нутагт хэрэгцээтэй, ач холбогдол бүхий төсөл хэрэгжих боломжийг бууруулж байна.

ЖДҮХС-гаар 2019 онд арьс шир боловсруулах, сүү, сүүн бүтээгдэхүүн, барилгын материал үйлдвэрлэх, хог хаягдал, дахин боловсруулах, ноос, ноолуур боловсруулах, мод, модон бүтээгдэхүүний салбар болон экспортод чиглэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, мал аж ахуйн гаралтай түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн нэгдсэн тогтолцоо-Загвар хоршоо, эрчимжсэн аж ахуйн чиглэлд төсөл шалгараагүй байна. /Дүрслэл 1, 2/

ЖДҮХС-гаас 2020 онд зоорь, хүлэмжийн аж ахуй, ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэх, сав, баглаа боодол үйлдвэрлэх, аялал жуулчлалын үйлчилгээ, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, ариутгал халдваргүйжүүлэлтийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх салбар болон стратегийн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, инновацын бүтээгдэхүүн нэвтрүүлэх, цахим худалдааны чиглэлд төсөл хэрэгжээгүй байна. /Дүрслэл 3, 4/

2019-2020 онд зарим салбарт төсөл хэрэгжихгүй байгаа нь дэд хороо нь ирүүлсэн төслийг хэрэгцээ, ач холбогдлоор нь эрэмбэлэхгүй байгаатай холбоотой байна.

ЖДҮ-ийн аймгийн зээл:

Аймгийн төсвийн санхүүжилтээр 2019-2021 онд ХАС банкаар дамжуулан олгосон 12 төслүүдээс 33.3 хувь нь сүү боловсруулах үйлдвэр, 25 хувь нь мах боловсруулах үйлдвэр, 8.3 хувь нь сав, баглаа боодлын үйлдвэр, 8.4 хувь нь барилгын материалын үйлдвэрлэл чиглэлд төслүүд шалгарч, 25 хувь нь салбар, чиглэлд багтаагүй төслүүд шалгарсан байна. /Дүрслэл 1/

Харин бүрэн найрлагат тэжээл, өвлийн хүлэмжийн аж ахуй, нөөшилсөн бүтээгдэхүүний үйлдвэр, гурилан бүтээгдэхүүн, зөгийн аж ахуй, шувууны аж ахуй, гахайн аж ахуй, оёмол бүтээгдэхүүн, ширэм хайлуулах, зуух угсрах, төмөр эдлэлийн чиглэлд төсөл хэрэгжээгүй нь сонгон шалгаруулалтын ажлын хэсэг ирүүлсэн төслүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлэхгүй, төсөл бүрд зээл олгож байгаатай холбоотой байна.

2.1.4. Аймгийн төсвөөс олгож буй ЖДҮ-ийн төслийг иргэд, олон нийтэд ил тод мэдээлж ажиллаагүй байна.

ЖДҮХС-гийн зээл:

Төсөл сонгон шалгаруулалт зарлаж, хүлээн авахдаа Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А-119 дүгээр тушаал “Жижиг, дунд үйлдвэрийг

хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журам"-ын 10.4²⁴-д төсөл хүлээн авахаас хуанлийн 10-аас доошгүй хоногийн өмнө олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарлаж, хуанлийн 14 хоногийн турш хүлээн авах, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоол "Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 10.2²⁵-т төсөл хүлээн авах зарыг мэдээлэх, 10.5²⁶-д төсөл хүлээн авах хугацааг 30 хоног байхаар тус тус заасан байна.

Журамд заасны дагуу 2019 оны ЖДҮ-ийн төсөл хүлээн авах зарыг 2019.05.17-27-ныг хүртэл хугацаанд аймгийн ХХААГ-ын албан ёсны фэйж хуудас, Enews, Дорнод, Шинэ суваг, D1, Мижи, PBS телевизүүдээр иргэд, олон нийтэд зарласан байна. ЖДҮ-ийн төслийн 2020 оны зарыг 2020.04.20-2020.05.19-ний өдрийг хүртэл аймгийн ЗДТГ-ын болон ХХААГ-ын албан ёсны фэйж хуудас, Жаран, Дорнод телевизээр 30 хоногийн хугацаанд зарлажээ.

Төслийг ХХААХҮС-ын 2019 оны А-119 дүгээр тушаал, Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолуудад заасан журмын дагуу төслийн иж бүрдэл шалгах, урьдчилсан судалгаа, нарийвчилсан судалгаа, хороо/дэд хорооны хурлаар хэлэлцэх зэрэг 4 үе шатаар үнэлж, цаасан суурь болон <http://office.smefund.gov.mn/> цахим хуудаст үнэлгээг хийсэн байна.

Төсөл сонгон шалгаруулалтын дэд хорооны шийдвэрээр 2019 онд нийт 14 ААН, иргэний төслийг хүсэлтийн дагуу холбогдох банкинд уламжилж, үйл ажиллагаа нь зогсонги байдалтай, барьцаа хөрөнгө хүрэлцэхгүй шалтгаанаар "Хүрэл төгс" ХХК, "Дорнын наяд баялаг" ХХК, иргэн Ш.Цэндийн төсөл Хаан банкны зээлийн хорооны шийдвэрээр хасагдаж, эрэмбийн дарааллаар "Буйр трэйвел" ХХК-ийн төсөл дэмжигдсэн байна.

ЖДҮ-ийн аймгийн зээл:

Орон нутгийн төсвийн санхүүжилтээр Хас банкаар дамжуулан 2009 оноос хойш олгож буй ЖДҮ-ийн төсөл хүлээн авах зарыг 2019, 2020 онд иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлж ажиллаагүй байна. Иргэд, аж ахуйн нэгжүүд төсөл хүлээн авах зарыг аман байдлаар авч ирсэн байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан "Хөнгөлөлттэй зээл олгох төслийг сонгон шалгаруулах ажлын хэсэг"-ийн хурлаар иргэн, аж ахуйн нэгжээс ирүүлсэн төслийг хэлэлцэн үнэлж дүгнэн, сонгон шалгаруулж ирсэн байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлсэн төслүүдийг тусгайлсан маягт, үнэлгээний хуудсаар үнэлж, дүгнэхгүй байгаа нь сонгон шалгаруулалтын журам байхгүйтэй холбоотой байна.

²⁴ Сан, аймгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллага нь төсөл хүлээн авахаас хуанлийн 10-аас доошгүй хоногийн өмнө олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарлана. Төслийг хуанлийн 14 хоногийн турш хүлээн авна.

²⁵ Жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага улсын хэмжээнд төсөл хүлээн авах зарыг өдөр тутмын мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх үүргийг хүлээнэ. аймаг, нийслэлийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллага нь энэхүү зарыг тухайн орон нутагт мэдээлэх үүргийг хүлээнэ. Төсөл хүлээн авах зард төсөл хүлээн авч эхлэх, дуусах хугацаа, байршил, цахим хаяг, зээлийн нөхцөл, холбоо барих утасны дугаар зэрэг мэдээллийг тусгасан байна.

²⁶ Жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэлийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан байгууллага нь төсөл хүлээн авах хугацааг олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарлаж, тухайн өдрөөс хойш хуанлийн 30 хоногийн хугацаанд цахимаар эсхүл цаасан хэлбэрээр хүлээн авна.

2.2. ЖДҮ-ийн чиглэлээр олгосон зарим зээлүүд зориулалт бусаар үр дүнгүй зарцуулагдсан байна.

2.2.1. Зээл авах сонирхол бүхий ЖДҮ эрхлэгчийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, судалгаа шинжилгээг хийгээгүй байна.

ЖДҮ эрхлэгчдээс ЖДҮ-ийн зээлд хамрагдахаар ирүүлсэн төслийн материалыг Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд заасны дагуу аймгийн ХХААГ-ын ЖДҮ хариуцсан мэргэжилтэн хүлээн авч эхний ээлжид төслийн иж бүрдлийг шалгаж, урьдчилсан судалгааг хийж, дараагийн шатанд шилжүүлж байна.

Аймгийн ХХААГ-т 2019, 2020 онуудад ЖДҮ эрхлэгчдээс нийт 107 төсөл ЖДҮХС-ийн зээлд хамрагдахаар ирүүлснээс 20 иргэн, ААН-д нийт 1,247.0 сая төгрөгийн зээл олгосон байна. Энэ нь зээлд хамрагдахаар ирүүлсэн ЖДҮ эрхлэгчдийн 18.7 хувь нь зээлд хамрагдсан байна. Үүнээс харахад ЖДҮ эрхлэгчдээс хөнгөлөлттэй зээлд хамрагдах хүсэл сонирхол их байгаа боловч орон нутагт хуваарилагдаж буй зээлийн хэмжээ бага байна.

Аудитаар зээл авах сонирхол бүхий ЖДҮ эрхлэгчийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, судалгаа шинжилгээ хийсэн эсэхийг үзэхэд хийгээгүй байна.

Иймд зээл авах сонирхол бүхий ЖДҮ эрхлэгчийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, судалгаа шинжилгээ хийх үйл ажиллагааг үе шаттайгаар үр дүнтэй зохион байгуулах шаардлагатай байна.

2.2.2. Зээлд хамрагдсан 2 ЖДҮ эрхлэгч зээлийн 64.0 сая төгрөгийг зориулалтын бус, үр дүнгүй зарцуулсан байна.

Дорнод аймагт Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эх үүсвэрээр 2019 онд 12 аж ахуйн нэгж, иргэнд 825.0 сая төгрөгийн, 2020 онд 8 аж ахуйн нэгж, иргэнд 422.1 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг тус тус олгосон байна.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эх үүсвэрээр 2019-2020 онд авсан хөнгөлөлттэй зээлийг ЖДҮ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэд зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулсан эсэхийг газар дээр нь очиж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд;

- “Билгүүнжаргал” ХХК нь барилга байгууламж барихад 30.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн ч төсөлд заагаагүй орон сууцны байр худалдан авахад 41.0 сая төгрөгийг зарцуулсан байна.
- “Түмэн олз” ХХК нь төсөлд заагаагүй зардалд нийт 23.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Эдгээр нь Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.8-т “Сангаас олгосон хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, зээлийн гэрээний үүргээ биелүүлэх,” гэсэн заалттай нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэлээ.

Дээрх ЖДҮ эрхлэгчид төслийн зээлийн 64.0 сая төгрөгийг төсөлд заагдсаны дагуу зарцуулаагүй нь 2019, 2020 онуудад олгосон нийт зээлийн 5.1 хувийг эзэлж байна.

Иймд төслийн зээлийг зориулалтын дагуу зарцуулахгүй, төслийн үндсэн зорилго, зорилт хангагдахгүй байгаад цаашид анхаарч ажиллах шаардлагатай байна.

Аудитын явцад “Буйр трэйвел” ХХК /100.0 сая төгрөгийн “Аялал жуулчлалын бааз төсөл”/, “Энх мөнх божу” ХХК /90.0 сая төгрөгийн “Талх нарийн боов төсөл”/-иудаас

төслийн үйл явц, зарцуулалтын тайланг шаардсан боловч заасан хугацаанд ирүүлээгүй нь зориулалтын дагуу зарцуулсан эсэхэд дүгнэлт гаргах боломжгүй байдал үүсгэлээ. Мөн ХХААГ-аас аж ахуйн нэгжүүдээс тайлан ирүүлэхийг шаарддаг ч дийлэнх ААН-үүд ирүүлэхгүй байгаа нь Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.9²⁷-д заасан үүргээ биелүүлэхгүй, хариуцлагагүй хандаж байгаатай холбоотой байна.

Иймд ЖДҮХС-гийн зээлд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлага үүссэн байна.

2.2.3. Аймгийн төсвийн эх үүсвэртэй зээлд хамрагдсан 2 ЖДҮ эрхлэгч зээлийн 24.8 сая төгрөгийг зориулалтын бус, үр дүнгүй зарцуулсан байна.

Аймгийн төсвийн эх үүсвэрээс жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газар Хас банкаар дамжуулан 2019 онд 7 аж ахуйн нэгж, иргэнд 179.9 сая төгрөгийн зээлийг, 2020 онд 4 аж ахуйн нэгж, иргэнд 98.6 сая төгрөгийн зээлийг тус тус олгосон байна.

Аудитын явцад аймгийн төсвийн эх үүсвэрээр 2019-2020 онд авсан зээлийг аж ахуйн нэгж, иргэд зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулсан эсэхийг газар дээр нь очиж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд;

- Баян-Уул сумын иргэн Д.Амгаланбаатар нь 30.0 сая төгрөгийн зээлийг сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх чиглэлээр авсан боловч төсөлд заасан үйл ажиллагаа явуулаагүй, зорилтот үр дүндээ хүрээгүй, 20.0 сая төгрөгийг зээлийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх нь нотлогдохгүй байна.
- Хэрлэн сумын иргэн А.Чойдогжамц нь 20.0 сая төгрөгийн зээлийг дугуй засвар, гагнуурын тоног төхөөрөмж авахаар төлөвлөсөн ч зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй, зээлийн үлдэгдэл 4.8 сая төгрөг байна. Төсөл хэрэгжүүлэгчээс энэ тухай тодруулахад зээлийг ажлын байрны халаалтын асуудлыг шийдэх, өөрийн хувийн зээлд зарцуулсан гэсэн тайлбарыг өгсөн.

Энэ нь Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.8-д "Сангаас олгосон хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, зээлийн гэрээний үүргээ биелүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэлээ.

Дээрх ЖДҮ эрхлэгчид төслийн зээлийн 24.8 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулаагүй нь нийт 2019, 2020 онуудад олгосон нийт зээлийн 13.7 хувийг эзэлж байна.

Иймд төслийн зээлийг зориулалтын дагуу зарцуулахгүй, төслийн үндсэн зорилго, зорилт хангагдахгүй байгаад цаашид анхаарч ажиллах шаардлагатай байна.

2.2.4. Аймгийн төсвийн эх үүсвэртэй зээлийн хүүгийн орлогоос зээл олгох нөхцөл боломж бүрдээгүй байна.

Дорнод аймагт жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор аймгийн төсвийн эх үүсвэрээр 2009 оноос Хас банкаар дамжуулан жижиг, дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдэд зээл олгож эхэлжээ.

Аймгийн Засаг даргаас Хас банкт хамтран ажиллах гэрээ байгуулснаар 2009 онд 233.2 сая төгрөгийг, 2010 онд 350.0 сая төгрөгийг тус банканд байршуулан ЖДҮ-ийг дэмжих зээл олгож эхэлсэн байна. Тус зээлийн хувьд зээл олгох харилцаа нь тусгайлсан журам, заавраар зохицуулагдаагүй ч 2 талын хоорондох гэрээгээр зохицуулагдаж байна.

²⁷ 13.2.9.зээлийн зарцуулалтын явц, байдлын талаарх тайланг Санд 6 сар тутам ирүүлэх;

Хас банкаар дамжуулан олгож буй зээлийн эргэн төлөлтийн орлогоос хамаарч 2019 онд 7 ЖДҮ эрхлэгчид 179.9 сая төгрөгийн зээлийг, 2020 онд 4 ЖДҮ эрхлэгчид 98.6 сая төгрөгийн зээлийг тус тус олгосон бөгөөд эдгээр зээлийн эргэн төлөлт хэвийн байна.

Харин зээлийн хүүгийн хувьд аймгийн Засаг даргын Хас банкттай 2018 онд байгуулсан гэрээний 4.4-т “Зээлийн хүүгийн орлогын 60 /хувь нь/ Хас банкны, 40 /хувь нь/ ЗДТГ-ын орлого болно.” гэж заасан бол 2020 онд байгуулсан гэрээний нэмэлт өөрчлөлтөд мөн адил заалттай байна. Гэрээнд заасны дагуу зээлийн хүүгийн орлогын 60 хувь нь Хас банкны орлого болж, 40 хувь нь орон нутгийн төсвийн орлого болж байгаа нь зээлийн хүүгийн эргэн төлөлтөөс зээл олгох боломжгүй нөхцөл байдалтай байна. Тухайлбал, 2019 онд бүрдсэн нийт зээлийн хүүгийн орлогын 60 хувь буюу 51.7 сая төгрөг нь Хас банкны орлого болж, 40 хувь буюу 20.7 сая төгрөг нь орон нутгийн төсвийн орлого болсон байна. Мөн 2020 онд бүрдсэн нийт зээлийн хүүгийн орлогын 60 хувь буюу 56.7 сая төгрөг нь Хас банкны орлого болж, 40 хувь буюу 22.7 сая төгрөг нь орон нутгийн төсвийн орлого болсон байна.

Иймд аймгийн төсвийн эх үүсвэрээр олгож байгаа зээлийн хүүгийн орлогоос зээл олгох нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Аймгийн Засаг даргаа Хас банкаар дамжуулан олгосон зээлийн эргэн төлөлтөд 2022 оны 8 дугаар сарын 30-ны байдлаар тулган баталгаажуулалт хийхэд 55.5 сая төгрөгийн 2 аж ахуйн нэгж муу зээлийн ангилалд байна. Тухайлбал, “Гэгээн тансаг өргөө” ХХК-ийн зээл төлж дуусах хугацаа 2020 оны 12 дугаар сард дууссан боловч үлдэгдэл 37.1 сая төгрөгийг төлөөгүй, “Дорнын алтан гутал” ХХК-ийн зээл төлж дуусах хугацаа 2023 оны 02 дугаар сард боловч зээлийн эргэн төлөлтийг хугацаа хоцроож 18.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Зээлийн гэрээний дагуу үлдэгдлийг төлж дуусаагүй, эргэн төлөлтийн хугацаа хэтрэлттэй байгаа нь дараагийн зээл олгох эх үүсвэр бүрдэхгүй байх эрсдэлийг үүсгэж байна. Тиймээс тухайн аж ахуйн нэгжүүдээс гэрээнд заасны дагуу зээлийн үлдэгдлийг хугацаанд нь барагдуулах талаар хууль, хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх нь зүйтэй байна.

БҮЛЭГ 3

Хөтөлбөр, төслүүд зорилтот түвшиндээ хүрээгүй, орон нутагт үр өгөөжөө өгөөгүй байна.

3.1. Хэрэгжсэн төслүүд зорилтот түвшиндээ хүрээгүй нь ЖДҮ-ийн зээлийн үр нөлөөг бууруулж байна.

3.1.1. Үндэсний болон дэд хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй, хөтөлбөрийн удирдлага, төлөвлөлт сул байна.

Үндэсний хөтөлбөр:

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 156 дугаар тогтоол “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн 3.1²⁸, 6.2²⁹-д зааснаар 6 зорилтод 8 үзүүлэлтээр хүрэх түвшинг тодорхойлсон байна.

Дорнод аймгийн ХХААГ нь 2019 онд үндэсний хөтөлбөрийн биелэлтийг гаргаж, үр дүнгийн талаар тайлагнасан эсэх нь баримтаар нотлогдохгүй байна. Мөн 2020 онд 6 зорилтын хүрээнд биелэлтийг тайлагнасан боловч хүрэх үр дүнг үнэлж, дүгнээгүй, бодитой, хэмжигдэхүйц, тодорхой, үр дүнд суурилсан байх шаардлагыг хангахгүй байна. Энэ нь хөтөлбөрийн удирдлага, төлөвлөлтийг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна.

Дэд хөтөлбөр:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 02 дугаар тогтоолоор “Орон нутагт жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийн 8.1, 8.2-т хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнгийн талаар заасан байна. Хүрэх үр дүнд үйлдвэр цехийн тоо 1-65, ажиллагсдын тоо 8-430-д хүрэхээр төлөвлөсөн байна.

Дэд хөтөлбөрийн 9.1³⁰, 9.2³¹-д зааснаар хэрэгжилтийн явцыг аймгийн Засаг даргын зөвлөл, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд танилцуулж, хэлэлцүүлэхээр заасан боловч зөвхөн 2019 онд ИТХ-ын Тэргүүлэгчдэд нэгжийн үйл ажиллагааны тайланг танилцуулсан төдий байна.

Дэд хөтөлбөрийн зорилт, хүрэх түвшинд үнэлэлт дүгнэлт, дүн шинжилгээ хийгдээгүй, дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг хэрэгжээгүй, байна.

²⁸ Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ:

3.1.1. жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох; 3.1.2. санхүү, хөрөнгө оруулалтын бодлогыг сайжруулах замаар жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд олгож буй зээлийн хүүг бууруулах, хугацааг уртасгах, санхүүгийн хөнгөлөлттэй нөхцөл бий болгон хүртээмжийг нэмэгдүүлэх; 3.1.3. зөвлөх үйлчилгээний салбарыг хөгжүүлэх; 3.1.4. инноваци болон байгальд ээлтэй техник, технологийг эрчимтэй нэвтрүүлэн, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадварыг сайжруулах; 3.1.5. жижиг, дунд үйлдвэрийн зах зээлийг өргөтгөх, борлуулалтад дэмжлэг үзүүлэх; 3.1.6. “Нэг суурин-Нэг бүтээгдэхүүн” аяныг зохион байгуулж, орон нутагт брэнд бүтээгдэхүүнийг бий болгох, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн бие даасан, бүтээлч байдлыг нэмэгдүүлэх.

²⁹ 6.2. Хөтөлбөрийн үр дүнг дараахь шалгуур үзүүлэлтээр тодорхойлно: Идэвхтэй үйл ажиллагаа эрхэлж байгаа жижиг, дунд үйлдвэр: Жижиг, дунд үйлдвэрийн салбарын ажилтан (шинээр бий болгох ажлын байр): Инкубатор, дэмжих төвд хамрагдсан жижиг, дунд үйлдвэр эрхлэгч: Сургалт, семинарт хамрагдсан жижиг, дунд үйлдвэр эрхлэгч: Жижиг, дунд үйлдвэрийн экспортод эзлэх хувь: Брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээ (орон нутагт бий болсон): Инноваци болон байгальд ээлтэй дэвшилтэт техник, технологи шинээр нэвтрүүлсэн аж ахуйн нэгж: Нэвтрүүлсэн олон улсын стандарт

³⁰ Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг жил бүрийн эцэст аймгийн Засаг даргын зөвлөлд болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд танилцуулж, хэлэлцүүлнэ.

³¹ Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, түүний үр дүнгийн талаарх мэдээ, тайланг холбогдох байгууллагууд цахим хуудсаар дамжуулан олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлнэ.

3.1.2. ЖДҮХС-гаас зээл авсан ААН-ийн 20 хувь нь брэнд бүтээгдэхүүн бий болгосон байна.

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөрийн 3.1.6³²-д орон нутагт брэнд бүтээгдэхүүнийг бий болгох, ЖДҮ эрхлэгчдийн бие даасан, бүтээлч байдлыг нэмэгдүүлэх талаар зорилт тавьсан байна.

ЖДҮХС-аас олгосон зээлийг төсөлд заасан зориулалтын дагуу ашиглаж, дотоодын зах зээл болон бусад улс, аймаг, хотын зах зээлд худалдан борлуулж өрхийн орлогоо нэмэгдүүлэхээс гадна орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг нэмэгдүүлсэн байна. Тухайлбал:

ЖДҮХС-гийн зээл:

“Бабу” ХХК-ийн “Шинэ технологи, брэнд бүтээгдэхүүн” төслийн хүрээнд аймгийн 9 гайхамшгийг агуулсан шинэ сав, баглаа боодол бүхий “Хөөмөл” боов, бусад нарийн боовыг шинэчлэн гаргаж, Улаанбаатар хотын сүлжээ дэлгүүрүүд болон хөрш зэргэлдээ аймгуудад борлуулж, шинээр 9 ажлын байрыг бий болгосон байна.

“Нутгийн тус” ХХК-ийн “Дорнод өндөг” төслийн хүрээнд Дорнод нэртэй өндгийг үйлдвэрлэлийн шатаар гаргаж, дотоодын зах зээлд нийлүүлж байгаа нь Хэрлэн сумын нийт өндөгний хэрэгцээний 7 хувийг хангаж байна. Шинээр 2 ажлын байр нэмэгдэж, 6 ажлын байрыг хадгалсан байна. /Жишиг хүн амын хоногийн нормоор хоногт Дорнод аймагт 1.31 тн буюу 116.2 мян.ш өндөг, Үүнээс Хэрлэн суманд 0.74 тн буюу 104.3 мян.ш өндөгний хэрэгцээтэй байна. – Эх үүсвэр: ХХААГ-ын мэдээлэл./

“Энх мөнх божу” ХХК-ийн “Талх, нарийн боов үйлдвэрлэлээ өргөжүүлэх” төслийн хүрээнд шинээр аяган бялуу, Донут кекс үйлдвэрлэж, дотоодын зах зээлд түгээн шинээр 4 ажлын байрыг нэмэгдүүлсэн байна.

“Эрхэт цог баян” ХХК-ийн “Гутлын үйлдвэр өргөжүүлэх” төслийн хүрээнд арьсан гутал үйлдвэрлэж, Сүхбаатар, Хэнтий аймаг болон дотоодын зах зээлд худалдан борлуулж, 2 ажлын байрыг хадгалсан байна.

Аймгийн ЖДҮ-ийн зээл:

Аймгийн төсвөөс 2019-2020 онд Хас банкаар дамжуулан олгосон зээлийн үр дүнд орон нутагт брэнд бүтээгдэхүүн бий болоогүй, нийт 11 төслөөс 2 нь зориулалтын дагуу тогтмол үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс “Маш итгэл” ХХК-ийн үйлдвэрлэл орон нутагт үйл ажиллагаа нь хумигдаж, Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэх болсон байна.

ЖДҮХС-аас зээл авч төсөл хэрэгжүүлсэн үйлдвэр эрхлэгчдийн бүтээгдэхүүнүүд нь жил бүрийн аймгийн ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуйн газраас зохион байгуулдаг үзэсгэлэн худалдаа арга хэмжээнээс “Брэнд бүтээгдэхүүн” гэсэн өргөмжлөлийг авч, ажлын байраа хадгалан импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаагаараа сайн туршлага болж байна.

Үйлдвэрлэл, бүтээгдэхүүн үйлчилгээний цар хүрээг авч үзвэл 2019-2020 онд хэрэгжиж эхэлсэн ЖДҮХС-гийн зээлийн хувьд нийт төслийн 4 буюу 20 хувь нь брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 8 буюу 40 хувь нь тогтмол бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 4 буюу 20 хувь нь улирлын чанартай /3 нь үйлдвэрлэл, 1 нь үйлчилгээ/, 4 буюу 20 хувь нь үйл ажиллагаа зогсонги байдалтай байна. Үүнээс үзвэл нийт төслийн 60 хувь нь тогтмол үйл ажиллагаа явуулж байна.

Аймгийн төсвөөс 2019-2020 онд олгосон ЖДҮ-ийн нийт төслийн 2 буюу 18 хувь нь үйл ажиллагаа зогссон байдалтай, 2 буюу 18 хувь нь үйл ажиллагаа явуулсан эсэх нь тодорхойгүй, нотлогдохгүй байна. Мөн 1 буюу 9 хувь нь зориулалт өөрчлөгдөж түрээсийн үйлчилгээ эрхэлж, 4 буюу 37 хувь нь улирлын чанартай, 2 буюу 18 хувь нь тогтмол үйлдвэрлэл эрхэлж байна.

³² “Нэг суурин - Нэг бүтээгдэхүүн” аяныг зохион байгуулж, орон нутагт брэнд бүтээгдэхүүнийг бий болгох, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн бие даасан, бүтээлч байдлыг нэмэгдүүлэх.


Үүнээс 4 төсөл нь үйлчилгээ үзүүлэхэд, 7 төсөл нь үйлдвэрлэл эрхлэхэд чиглэж байгаагаас тогтмол үйлдвэрлэл эрхэлж байгаа төслүүдээс брэнд бүтээгдэхүүн бий болоогүй байна.

3.1.3. ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагаа нь тогтмолжоогүй байна.

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөрийн 5.1³³, 5.3³⁴-д ЖДҮ эрхлэгчийн тоо нэмэгдэж, үйлдвэрийн тоо, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний хэмжээ нэмэгдсэн байх талаар хүрэх үр дүнг тодорхойлсон байна.

Дорнод аймгийн хэмжээнд 2019 онд шинээр 126 аж ахуй нэгж шинээр байгуулагдсанаас аймгийн ХХААГ-т бүртгэлтэй, ЖДҮ эрхлэх сонирхол бүхий 5 үйлдвэр, аж ахуйн нэгж байна.

Дүрслэл 3. “ХХААГ-т бүртгэлтэй шинээр байгуулагдсан үйлдвэрийн судалгаа 2018-2020”



Эх сурвалж: УБХ, ХХААГ-ын үйлдвэр, аж ахуйн нэгжийн судалгаа /2018-2020/


Харин 2020 онд шинээр байгуулагдсан 131 аж ахуйн нэгж байгаагаас аймгийн ХХААГ-т бүртгэлтэй, ЖДҮ эрхлэх сонирхол бүхий тогтмол үйл ажиллагаа явуулж буй 5 үйлдвэр, аж ахуйн нэгж байна.

ЖДҮХС-гийн хөрөнгөөр 2019-2020 онд хэрэгжсэн 20 төслөөс үйл ажиллагаа нь тогтмол явагдаж байгаа 12 иргэн, ААН, улирлын чанартай үйл ажиллагаа эрхэлж байгаа 4 иргэн, ААН, үйл ажиллагаа явуулахгүй, зогсонги байдалтай байгаа 4 ААН байна. /Дэлгэрэнгүй судалгааг хавсаргав./

³³ 5.1. Татвар, хөнгөлөлттэй зээл, зээлийн батлан даалт, лизинг, даатгалын үйлчилгээнд хамрагдсан жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн тоо нэмэгдсэн байна.

³⁴ 5.3. Ханган нийлүүлэх бодлого хэрэгжсэнээр боловсруулах үйлдвэрийн тоо, бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний хэмжээ нэмэгдэнэ.

Дүрслэл 4. “ААН, иргэдийн төслийн үйл ажиллагааны судалгаа – ЖДҮХС”




Эх сурвалж: Аудиторын судалгаа, ажиглалт, тулган баталгаажуулалт

- Улирлын чанартай үйл ажиллагаа эрхэлж байгаа 4 ААН /"Сод хийц", "Гялс оёдол", "Хүнс ногооны хадгалалт боловсруулалт", "Буйр нуур аялал жуулчлал"/ иргэд нь түүхий эдийн гарц, тариалалт, үйлдвэрлэлийн түрээс, дулааны улиралд орж ирэх орлогоос хамааран байнгын үйл ажиллагаа эрхлээгүй байна.
- Үйл ажиллагаа нь зогсонги байгаа "Билгүүн жаргал" ХХК, "Авто агро" ХХК-иудын төсөл зорилтот үр дүндээ хүрээгүй, бүтээгдэхүүн үйлдвэрлэхгүй байгаа нь ковид-19 цар тахлаас шалтгаалан тоног төхөөрөмжийн татан авалт хойшлогдсонтой холбоотой байна.
- "Баян аят" ХХК-ийн төсөл зорилтот үр дүндээ хүрээгүй, бүтээгдэхүүн үйлдвэрлэхгүй байгаа нь ЖДҮХС-аас хуваарилсан санхүүжилт хүрээгүйн улмаас нийт санхүүжилтийн 24 хувийг авсантай холбоотой, тоног төхөөрөмжөө худалдан авч чадаагүй байна.
- "Түмэн олз" ХХК-ийн төсөл зорилтот үр дүндээ хүрээгүй, бүтээгдэхүүн үйлдвэрлэхгүй байгаа нь төслийн явц удааширсантай холбоотой байна.

Аймгийн ЖДҮ-ийн хөрөнгөөр 2019-2020 оноос хэрэгжиж эхэлсэн 11 төслөөс үйл ажиллагаа нь тогтмол хэвийн явагдаж байгаа 2 ААН, улирлын чанартай 4 иргэн, ААН, үйл ажиллагаа нь өөрчлөгдөж бусдад түрээслүүлсэн 1 иргэн, үйл ажиллагаа нь зогсонги байдалтай байгаа 2 иргэн, аудитын явцад төслийн үйл явцыг танилцуулаагүй, үйл ажиллагаа явагдсан эсэх нь тодорхойгүй 1 иргэн, 1 хоршоо байна. /Дэлгэрэнгүй судалгааг хавсралтаас/

Дүрслэл 5. “ААН, иргэдийн төслийн үйл ажиллагааны судалгаа – Аймгийн ЖДҮ”



Эх сурвалж: Аудиторын судалгаа, ажиглалт, тулган баталгаажуулалт

- Улирлын чанартай үйл ажиллагаа эрхэлж байгаа 4 ААН, иргэдийн орлого олох боломж нь дулааны улиралд илүү бүрдсэн учраас байнгын үйл ажиллагаа эрхлээгүй байна. /"Шим", "Авто сэлбэг, дугуй засвар", "Арвижих", "Өөдлөх ирээдүй" төсөл /
- "Фермерийн аж ахуй, сүү цагаан идээ боловсруулах" /8-р баг/ төсөл нь цар тахлын улмаас төслийг бүрмөсөн зогсоосон. "Хуванцар сав, хог хаягдал боловсруулах" төсөл нь цар тахалтай холбоотой, нийлүүлэлт багассанаас үйлдвэрлэл түр зогссон байдалтай байна.
- Баян-Уул, Матад сумын "Мах сүүний чиглэлийн үхэр өсгөх", "Бүх төрлийн сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх" төслүүд нь үйл ажиллагаа эрхэлсэн нь нотлогдохгүй, зорилтот үр дүндээ хүрээгүй байна.
- "Авто засвар үйлчилгээ" /10-р баг/ төсөл нь санхүүжилт бага, цар тахлаас шалтгаалан тоног төхөөрөмж авч чадаагүйгээс зорилтот үр дүндээ хүрэлгүй засварын төвийн объектыг бусдад түрээслэх үйлчилгээ үзүүлсэн байна.


Дээрх судалгаанаас үзвэл ЖДҮХС-гаас олгосон 20 зээлдэгчийн 60 хувь, аймгийн төсвөөс олгосон ЖДҮ-ийн 11 зээлдэгчээс 2 нь буюу 9 хувь тогтмол үйл ажиллагаа эрхэлж байна.

3.1.4. Төлөвлөсөн ажлын байрыг бий болгоогүй байна.

Үндэсний болон орон нутгийн ЖДҮ-ийг хөгжүүлэх хөтөлбөр, дэд хөтөлбөрт ажлын байрыг нэмэгдүүлэх талаар тусгагдсан.

ЖДҮХС-гаас 2019, 2020 онд олгосон зээлийн дагуу төслийн үр дүнд 3 иргэн, 17 аж ахуйн нэгж нь 129 ажлын байр нэмэгдүүлэхээр төлөвлөснөөс 2022 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар 81 ажлын байр буюу 62.8 хувийн биелэлттэй байна.


Дүрслэл 6. "ЖДҮХС - 2019, 2020 оны ажлын байрны судалгаа"



Эх сурвалж: Аудиторын хийсэн судалгаа, харьцуулсан дүн шинжилгээ

Аймгийн төсвөөс Хас банкаар дамжуулан 2019, 2020 онд олгосон зээлийн дагуу 8 иргэн, 3 аж ахуйн нэгж нь нийт 77 ажлын байраар нэмэгдүүлэхээр төлөвлөснөөс 2022 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар 29 ажлын байр шинээр нэмэгдсэн нь ажлын байр 37.6 хувийн хэрэгжилттэй байна.

Дүрслэл 7. “Аймгийн ЖДҮ-ийн 2019, 2020 оны ажлын байрны судалгаа”



Эх сурвалж: Аудиторын хийсэн судалгаа, харьцуулсан дүн шинжилгээ

Аудитын явцад хийсэн ярилцлага, ажиглалтаар үйлдвэр, аж ахуйн нэгжийн ажиллагсад нь НДШ төлөх сонирхолгүй байгаагаас холбогдох мэргэжлийн байгууллагуудын ажлын байрны статистик мэдээлэл зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

3.2. Хөтөлбөр, төслийн хэрэгжилт хангалтгүй, хяналт үр нөлөө багатай байна.

3.2.1. ЖДҮ-ийн 2020 оны зээлд хамрагдсан төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаагүй байна.

Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл, олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-д сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, зээлийн эргэн төлөлтөд хяналт тавих үүргийг Жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлэхээр заасан.

Аймгийн түвшинд ЖДҮ-ийн зээлийн зарцуулалтад хяналт тавих үүрэг нь дээрх журам болон тусгайлсан журам, заавраар зохицуулагдаагүй ч арилжааны банкаар дамжуулан 2019 онд зээл авсан зээлдэгчийн үйл ажиллагаанд аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн, ХХААГ-ын жижиг, дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтэн нар 2020 оны 02 сард газар дээр нь очиж хяналт тавьж ажилласан байна. Мөн аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн даргын баталсан удирдамжийн дагуу аймгийн ХХААГ-ын даргаар ахлуулсан 6 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг орон нутгийн Жаран телевизтэй хамтран 2021 оны 2 сард хяналт тавьж ажилласан байна. Энэ ажлын хэсэг хөнгөлөлттэй зээл авсан аж ахуйн нэгж, иргэдийн ажлын байранд газар дээр нь очиж төсөл хэрэгжүүлэгчтэй ярилцаж, хяналт үнэлгээг хийж ажилласан байна.

Харин 2020 оны зээлийн хэрэгжилтэд холбогдох байгууллага, албан тушаалтнууд хяналт тавьж ажиллаагүй байна. Энэ нь ковид-19 цар тахлын нөхцөл байдалтай холбоотой байна.

Иймд зээлд хамрагдсан төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

3.2.2. Орон нутгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ үр дүнтэй хийгдээгүй байна.

Засгийн газрын 2019 оны 156 дугаар тогтоолоор батлагдсан "Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр"-ийн 8.1-д "Жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, шаардлагатай бол хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулна." гэж заасны дагуу ХХААХҮЯ-аас үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгддэг байна. Тухайлбал, 2020 оны хэрэгжилтийн явцад хийгдсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дунджаар 89.5 хувьтай үнэлэгдсэн байна.

Аудитаар аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутагт жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх дэд хөтөлбөр"-ийн 2019, 2020 оны хэрэгжилтийн явцад аймгийн ЗДТГ-ын ХШҮ-ний хэлтсээс хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн эсэхийг үзэхэд дэд хөтөлбөрийн 2019 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй, 2020 оны хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр 76.4 хувьтай үнэлэгдсэн байна. Үүнээс үзэхэд дэд хөтөлбөр батлагдсанаас хойш жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ үр дүнтэй хийгдээгүй байна.

3.2.3. Орон нутгаас хөтөлбөрийн хэрэгжилтийг зөвхөн гарцын үзүүлэлтээр тайлагнаж, дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хэлэлцүүлж, үнэлээгүй байна.

"Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр" Засгийн газрын 2019 оны 156 дугаар тогтоолын нэг дүгээр үе шатны хэрэгжилтийг 2019 онд хүргүүлсэн эсэх нь тодорхойгүй, харин 2019-2020 оны хөтөлбөрийн биелэлтийг Дорнод аймгийн ХХААГ-аас тайлагнаж ЖДҮГ-т хүргүүлсэн байна.

Аймгуудын ХХААГ-ын 2019 оны ажлын үр дүнд хөнгөн, ЖДҮ-ийн үйл ажиллагааны үр дагаварт Дорнод аймаг хяналт, шинжилгээ үнэлгээгээр 84.1 хувь авч 21 аймгаас сүүлийн байранд эрэмбэлэгдсэн ба 2020 онд дээрх үзүүлэлтээр 85.1 хувь болж өсөн 12 дугаар байранд эрэмбэлэгдсэн байна.

Харин орон нутагт "Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгж" нь 2019, 2020 оны ажлын тайланг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулсан байна.

"Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн хувьд 2019 оны хэрэгжилт үр дүнгүй тайлагнагдсан байна. 2020 оны хэрэгжилтийн хувьд хяналт, шинжилгээ үнэлгээгээр 1 хувиар өсөж, аймгуудтай харьцуулахад 12 дугаар байранд эрэмбэлэгдэж хэрэгжилтийн тайлагнал өмнөх оноос 9 байраар дээшилсэн үзүүлэлттэй байна.

Дэд хөтөлбөрийн тухайд хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн Засаг даргын зөвлөл болон ИТХ-д танилцуулж, хэлэлцүүлээгүй байна.

3.2.4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ЖДҮГ нь нэгтгэн мэдээлдэг байна. Орон нутагт тусгайлан төсөв хөрөнгө батлагдаж ирдэггүй, ЖДҮГ-т нэгдсэн данстай, уг дансаар санхүүжилт хуваарилагддаг тул, тусгайлан мэдээлэх цэс байхгүй байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:


**ДОРНОД АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**
21000, Чойбалсан, Дорнод аймаг,
Утас: 7058-3040, факс: 7058-4681

Б.Зоригт
Дүнэмтэй ив-
дүгнэлт
2020.11.10 № *5444*
төрийн _____ -ны № _____ -т

**ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.БОЛОРТУУЛ ТАНАА**

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр
Хас банкаар дамжуулан 2011-2021 онуудад олгосон
зээлд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй
танилцлаа.

Цаашид зөвлөмжийн дагуу хэрэгжилтийг
хангуулахад анхаарч ажиллана.

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА М.НЯМСҮРЭН



0101 1537

"Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны үр нөлөө"-нд
хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжтэй холбоотой санал, тайлбар

Санал 1:

Тус тайлангийн 3 дугаар бүлгийн 3.1.1 дүгээр дүгнэлтэд "Үндэсний болон
дэд хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй, зорилтот түвшинг үр дүнтэй тайлагнаж,
үнэлээгүй байна" гэж тодорхойлсон нь илэрсэн асуудлын үндсэн шалтгаанд
чиглээгүй байна. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнтэй тайлагнагдаагүй нь
хөтөлбөрийн хүрээнд тухайн онд Дорнод аймагт ямар арга хэмжээг, ямар нөөцөөр
хэрэгжүүлж, ямар үр дүнд хүрсэн байхыг төлөвлөөгүйтэй нягт холбоотой. Үндэсний
хөтөлбөр зорилтот түвшиндээ хүрэх нөхцөл нь хөтөлбөрийн удирдлага буюу
төлөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлагналаас бүрэн хамаарна.
Үндэсний хөтөлбөрийн хүрээнд тухайн онд хэрэгжүүлэх арга хэмжээг Дорнод
аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө /хуучнаар үр
дүнгийн гэрээ/-нд тусгаж төлөвлөсөн бөгөөд аудитад хамаарч буй 2019-2020 онд
тус чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ нь зөвхөн зохион байгуулалтын арга
хэмжээнүүд байсан. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй, зорилтот
түвшинг үр дүнтэй тайлагнаагүй шалтгаан нь хөтөлбөрийн удирдлага,
төлөвлөлтийн алдаанаас болсон.

Иймд "Үндэсний болон дэд хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй, зорилтот
түвшинг үр дүнтэй тайлагнаж, үнэлээгүй байна" гэх дүгнэлтийг "Үндэсний болон
дэд хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй, хөтөлбөрийн удирдлага сул байна" гэж
дүгнэх нь агуулга, бодит байдалд нийцнэ гэж үзэж байна.

Санал 2:

Тус тайлангийн 3 дугаар бүлгийн 3.2.3 дугаар дүгнэлтэд "Орон нутгаас
хөтөлбөрийн хэрэгжилтийг хангалтгүй тайлагнасан байна" гэж тодорхойлсон
үндэслэл нь бодит байдалтай нийцэхгүй байна. Учир нь уг дүгнэлтийг гаргахдаа
Хүнс, хөдөө аж ахуйн газраас 2020 онд ЖДҮГ-т хүргүүлсэн үндэсний хөтөлбөрийн
тайланд хийсэн үнэлгээ бус аймгийн ЖДҮ, Хөнгөн үйлдвэрлэлийн тухайн жилийн
хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээгээр дүгнэсэн байна.

Хүнс, хөдөө аж ахуйн газраас үндэсний хөтөлбөрийн тайланг
боловсруулахдаа дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний хүрээнд тухайн онд
хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, гарцыг тайлагнасан. Тухайн гарц нь салбарт ямар үр


**ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТААГ
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР**
21071, Дорнод аймаг, Хүрэн сум, 10 дугаар баг
Утас/Факс: 7058-5111

2020.11.11 № *498*
тайвч _____ -ны № _____ -т

**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Б.БОЛОРТУУЛ ТАНАА**

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас
2019, 2020 онд олгосон зээлийн үйл ажиллагаа,
үндэсний хөтөлбөрийн тайлагналтад хийсэн аудитын
тайлангийн төсөлтэй танилцлаа.

Аудитын үйл ажиллагаатай холбоотой санал,
тайлбарыг хүргүүлэв.

Хавсралт: 7 хуудастай



690622629

нөлөө үзүүлсэн тодорхойлоогүй тохиолдолд тухайн хэрэгжүүлсэн ажлын үнэлгээ
нь салбарын хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээтэй уялдахгүй.

Иймд "Орон нутгаас хөтөлбөрийн хэрэгжилтийг хангалтгүй тайлагнасан
байна" гэх дүгнэлтийг "Орон нутгаас үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зөвхөн
гарцын үзүүлэлтээр тайлагнасан, дэд хөтөлбөрийн тайланг дүгнээгүй" байна гэж
өөрчлөх нь агуулга, бодит байдалтай нийцнэ гэж үзэж байна.

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР

САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:

1. Тайлангийн төсөлд өгсөн Дорнод аймгийн ХХААГ- албан бичгээр ирүүлсэн санал, тайлбарын дагуу тайлангийн 3.1.1, 3.2.3 дахь хэсэгт найруулгын өөрчлөлтийг тусгав.
2. Дорнод аймгийн “Билгүүнжаргал” ХХК, иргэн Д.Амгаланбаатараас ирүүлсэн тайлбар нь хангалттай бөгөөд зохистой нотлох баримтын шаардлагыг хангахгүй байгаа тул төлбөрийн актыг хэвээр үлдээхээр шийдвэрлэв.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Орон нутагт ЖДҮ-г хөгжүүлэх эрх зүйн орчин хангалттай бүрдээгүйн улмаас кластераар хөгжүүлэх бодлого, төрийн зарим байгууллагын бүтэц чиг үүрэг оновчтой тодорхойлогдоогүй байна.
2. Аймгуудад хуваарилах санхүүжилтийн төлөвлөлтийг бодит тооцоо судалгаанд үндэслэж, хуваарилахгүй байгаа нь орон нутагт хэрэгжиж буй төслүүдийн зорилтот үр дүнд сөргөөр нөлөөлж, үр нөлөөг бууруулж байна. Банкаар дамжуулан олгох бодлого төрийн бодлоготой бүрэн нийцэхгүй байгаагаас гадна төсөл сонгон шалгаруулалтын явц удааширнаас ЖДҮ эрхлэгчдэд санхүүжилт оройтож ирж байна.
3. ЖДҮХС-гийн сонгон шалгаруулалтын дэд хороог журмын дагуу байгуулсан боловч ЖДҮ-ийн төслүүдийг орон нутгийн хэрэгцээ, ач холбогдлоор нь эрэмбэлэхгүй, зөвхөн нийт онооны системээр шалгаруулж байгаа нь учир дутагдалтай байна.
Аймгийн төсвөөс олгож буй ЖДҮ-ийн зээлийн хувьд дүрэм, журамгүй байгаагаас төсөл олон нийтийг мэдээллээр хангах, орон нутгийн хэрэгцээ шаардлагыг хангасан төсөл хэрэгжихгүй байх зэрэг эрсдэлийг үүсгэхээс гадна ирүүлсэн төсөл бүрийг эрэмбэлж зээл олгож байгаа нь ЖДҮ-ийн ач холбогдлыг бууруулж байна.
4. ЖДҮХС болон аймгийн төсвөөс олгосон ЖДҮ-ийн зээлээс нийт 150.0 сая төгрөгийг зориулалт бусаар үр дүнгүй зарцуулсан байгаа нь төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, иргэдийн хариуцлага сул, зарим ААН-үүд зээлийн үйл ажиллагаа, зарцуулалтын тайланг ХХААГ-т хугацаанд нь гаргаж ирүүлэхгүй байгаа нь хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байгаатай холбоотой байна.
5. ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагаа тогтмолжоогүй, төлөвлөсөн ажлын байрыг нэмэгдүүлээгүй байгаа нь үндэсний болон дэд хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй, төрөөс хэрэгжиж буй бодлого шийдвэр үр нөлөөгөө бүрэн өгөхгүй байгааг харуулж байна.
6. Үндэсний болон дэд хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй, хэрэгжилтийг бодитой, үр дүнтэй тайлагнаагүй байна. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг үр дүнтэй тайлагнаагүй, ИТХ-аар хэлэлцүүлээгүй байгаа нь хяналт сул байгааг харуулж байна.

Аудитаар нийт 204.3 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 88.8 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, 60.0 сая төгрөгийн 1 албан шаардлага, 55.5 сая төгрөгийн 19 зөвлөмж өгч, холбогдох байгууллагад уламжлах 3 саналыг Үндэсний аудитын газарт хүргүүлээ.

УЛАМЖЛАХ САНАЛ:

Үндэсний аудитын газарт:

1.1.3. ЖДҮ-ийг дэмжих төвийн бүтэц, чиг үүргийн талаар хууль, дүрэм журамд тусгуулж, зохицуулалт хийх талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжлах.

1.2.1. ЖДҮХС-гийн зээлийн санхүүжилтийг төлөвлөхдөө аймгуудын өрсөлдөх чадвар болон түүнийг тодорхойлогч хүчин зүйлүүд болох хүн амын тоо, ЖДҮ эрхлэгчдийн тоог харгалзан үзэж хуваарилах талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжлах. /СЯ, ХХААХҮЯ, ЖДҮГ/

1.2.4. “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журам”-д өөрчлөлт оруулж, банкаар дамжуулан олгох нөхцөл, шалгуурыг уян хатан болгох.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга /М.Бадамсүрэн/-д:

1.1.2. Кластераар бүсчлэн хөгжүүлэх төлөвлөгөөг бодитой тооцоо судалгаанд үндэслэж, эдийн засгийн үр нөлөөг тооцоолж орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөнд үе шаттайгаар тусгаж ажиллах.

1.1.5. Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан төрөөс ЖДҮ-гийн талаар баримталж буй бодлого, чиглэлийг орон нутгийн бодлогод бүрэн тусгаж ажиллах.

1.2.4. Аймгийн ЗДТГ-аас олгож буй ЖДҮ-ийн зээлийг банкаар дамжуулан олгохдоо ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.2, 17.1-д заасныг үндэслэн нээлттэй сонгон шалгаруулах.

2.1.2. ЖДҮ-ийг хөгжүүлэх аймгийн ерөнхий чиглэлийг үйл ажиллагаандаа баримталж, төсөл сонгон шалгаруулалтыг үр дүнтэй зохион байгуулах.

2.1.3. ЖДҮ-ийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг баримталж, ач холбогдол багатай төслийг сонгон шалгаруулахгүй байх.

2.1.4. Аймгийн ЖДҮ-ийн төсөл сонгон шалгаруулалт зарлах, төсөл хүлээн авах, үнэлэх үйл явцыг олон нийтэд нээлттэй, ил тод зохион байгуулах талаар журам батлуулж, мөрдөх.

2.2.4. Гэрээний хугацаа дууссан болон хугацаа хэтэрсэн ААН-үүдийн зээлийн үлдэгдлийг хугацаанд нь барагдуулах талаар хууль, хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх.

3.1.1. Дэд хөтөлбөрийг бодитой, хэмжигдэхүйц, тодорхой, үр дүнд суурилсан байх зарчмын хүрээнд тайлагнаж байх.

3.1.3-3.1.4. Төсөл хэрэгжүүлж байгаа ЖДҮ эрхлэгчийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, тогтмол үйл ажиллагаа эрхлэх, ажлын байрыг хадгалах, нэмэгдүүлэх талаар зөвлөн туслах үйлчилгээг үр дүнтэй зохион байгуулах.

3.2.1. ЖДҮ-ийн зээлд хамрагдсан төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах.

3.2.2. Орон нутгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг үр дүнтэй хийх

Аймгийн ХХААГ-ын дарга /Ж.Алимаа/-д:

2.2.1. Зээл авах сонирхол бүхий ЖДҮ эрхлэгчийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, судалгаа шинжилгээг хийж байх.

3.1.1. Үндэсний хөтөлбөрийг бодитой, хэмжигдэхүйц, тодорхой, үр дүнд суурилсан байх зарчмын хүрээнд тайлагнаж байх.

3.1.3-3.1.4. Төсөл хэрэгжүүлж байгаа ЖДҮ эрхлэгчийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, үйл ажиллагаа тогтмол явуулж, ажлын байрыг хадгалж, нэмэгдүүлэх талаар зөвлөн туслах үйлчилгээг үр дүнтэй зохион байгуулах.

3.2.1. ЖДҮ-ийн зээлд хамрагдсан төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах.

3.2.3. Орон нутагт хэрэгжсэн хөтөлбөрийн зорилтуудын хүрээнд хийгдсэн ажлуудыг хүрсэн үр дүнтэй, хэмжигдэхүйц, бодитойгоор тайлагнаж, холбогдох газарт хүргүүлж байх.

Аймгийн ЖДҮ дэмжих төвийн захирал /Д.Чимгээ/-д:

3.1.3-3.1.4. ЖДҮ-ийн зээлд хамрагдсан иргэд, ААН-үүдэд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ сайжруулж, төлөвлөсөн ажлын байрыг нэмэгдүүлж, хадгалах талаар зөвлөн туслах үйлчилгээг үр дүнтэй зохион байгуулж хэвших.

Хас банкны Дорнод салбарын захирал /Э.Жаргалсайхан/-д:

2.2.4. Аймгийн төсвийн эх үүсвэрээр олгож байгаа зээлийн хүүгийн орлогоос зээл олгох нөхцөлийг бүрдүүлж ажиллах. Гэрээний хугацаа дууссан болон хугацаа хэтэрсэн ААН-үүдийн зээлийн үлдэгдлийг хугацаанд нь барагдуулах талаар хууль, хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх.

3.2.1. ЖДҮ-ийн зээлд хамрагдсан төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах.

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2023 оны 11 дүгээр сарын 05-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2022 оны 11 сарын 15 өдөр

Дугаар А/24

Чойбалсан хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны үр нөлөө"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор /Д.Энхболд/, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /М.Энхтөр/, аймгийн Засаг дарга /М.Бадамсүрэн/, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга /Ж.Алимаа/, аймгийн "Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв" ОНӨААТҮГ-ын захирал /Т.Чимгээ/, "Хас банк"-ны Дорнод салбарын захирал /Э.Жаргалсайхан/ нарт тус тус хүргүүлсүгэй.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Я.Зориг)-д даалгасугай.



Б.БОЛОРТУУЛ

011010095

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны
11... дүгээр сарын 15... -ны өдрийн 494 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

Аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт

№	Төлбөр, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /сая төгрөг/	Төлбөр, зөрчил хариуцах	
			Байгууллага	Албан тушаалтан
1.Төлбөрийн акт				
1	Иргэн Д.Амгаланбаатарын 30.0 сая төгрөгийн төслөөс 20.0 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх нь нотлогдохгүй, иргэн А.Чойдогжамцын 20.0 сая төгрөгийн төслөөс зориулалтын дагуу зарцуулаагүй, зээлийн үлдэгдэл 4.8 сая төгрөг байна.	24.8	АЗДТГ	Засаг дарга М.Бадамсүрэн
2	"Билгүүнжаргал" ХХК нь төслийн дагуу барилга байгууламж барихад 30.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн ч төсөлд заагдаагүй орон сууц худалдан авахад 41.0 сая төгрөгийг, "Түмэн олз" ХХК нь төсөлд заагдаагүй зардалд нийт 23.0 сая төгрөгийг зориулалт бусаар тус тус зарцуулсан байна.	64.0	ХХААГ	Дарга Ж.Алимаа
Дүн		88.8		
2. Албан шаардлага				
1	1. Зүүн бүсийн ЖДҮ-ийн тэргүүлэх ач холбогдол бүхий салбар, Дорнод аймгийг 2022-2024 онд жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлд багтаагүй 60.0 сая төгрөгийн санхүүжилттэй авто болон дугуй засварын 3 төслийг сонгон шалгаруулсан байна. 2. Хас банкаар дамжуулан 2019, 2020 онд олгох ЖДҮ-ийн төсөл хүлээн авах, сонгон шалгаруулалтын талаар иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлж ажиллаагүй байна. 3. 2019, 2020 онд олгосон зээлийн дагуу 8 иргэн, 3 аж ахуйн нэгж нь нийт 77 ажлын байраар нэмэгдүүлэхээр төлөвлөснөөс 2022 оны 09 дүгээр сарын 30-ны байдлаар 29 ажлын байр нэмэгдсэн нь 37.6 хувийн биелэлттэй байна.	60.0	АЗДТГ	Засаг дарга М.Бадамсүрэн
Нийт дүн		148.8		

Тайлангийн хавсралт 1

Дорнод аймагт ЖДУХС-аас болон банкаар дамжуулан олгосон ЖДҮ-ийн эзэлийн хэрэгжилтийн судалгаа

2022.10.17														
№	Төслийн нэр	Төслийн байршил /сумын нэр/	Зээлдэгч иргэн, ААН-ын нэр	Регистр	Төслийн чиглэл	Зээлийн ангилал /Мүү, эргэлзээтэй, хэвийн/	Зээл дуусах огноо	Зээл зориулал- тын дагуу эсэх /Тийм, үгүй/	Ажлын байр		Шинээр бий болсон бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр	Үйл ажиллаг аа нь тогтмол явагдаж	Төслийн хаяг, байршил	Холбоо барих утасны дугаар
2019 он														
1	Шимт хүнс	Хэрлэн сум 6-р баг Худалдааны гудамж	"Эрдэнэбилгүүдэй" ХХК	3367436	Хагас боловсруулсан бүтээгдэхүүн	Хэвийн	хаасан	тийм	11	7	Дайвар бүтээгдэхүүн	тийм	Хэрлэн сум, 6-р баг, Худалдааны гудамж	88078400
2	Сод хийц бизнес төсөл	Хэрлэн сум 10-р баг 27-р байр 1-р орчны пудвол	Д.Батболд	ЖЛ87040919	Мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл	Хэвийн	2025.04.	тийм	3	3	Гэрийн тавилга	улирал	Хэрлэн сум 10-р баг 27-р байр 1-р орчны пудвол	88583319
3	Гялс оёдол	Хэрлэн сум 6-р баг Силикат	Д.Оюунбаатар	ЖЛ64093019	Оёмол бүтээгдэхүүн	Хэвийн	2024.09.05	тийм	6	3	Эмнэлгийн ажилтны хувцас	улирал	Хэрлэн сум 6-р баг Силикат	99578751, 90083737
4	Үйлдвэрлэлийн хүчин 4 чадал нэмэгдүүлэх төсөл	Хэрлэн сум 7-р баг Дөрөөт төв	ОРУМ ХХК	3371689	Сүү, сүүн, мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	Хэвийн	2024.10.16.	тийм	15	3	Нэмэгдээгүй хуучин хяам	тийм	Хэрлэн сум 7-р баг Дөрөөт төв	99290776
5	Амттан үйлдвэр шинэ технолог, брэнд бүтээгдэхүүн	Хэрлэн сум Ивээл 34-01	БАБУБ ХХК	2628643	Талх, нарийн боов үйлдвэрлэл	Хэвийн	2024	тийм	9	9	Хөөмөл боов	тийм	Хэрлэн сум Ивээл 34- 01	99074646
6	Чацаргана боловсруулах үйлдвэрлэл	Хэрлэн сум 1-р баг	Авто агро ХХК	2776707	Чацаргана үйлдвэрлэл	Хэвийн	хаасан	тийм	6	1	шинэ гаргасан бүтээгдэхүүн байхгүй	зогсонги/ үр	Хэрлэн сум 1-р баг	99581920
7	Хүнсний ногооны хадгалалт боловсруулалт	Хэрлэн сум 6-р баг	Сэмбо БГБХН	2237539	Төмс, хүнсний ногооны тоног техөөрөмж	Хэвийн	2024, 10	тийм	8	6	зоорь	улирал	Хэрлэн сум 1-р баг	89989744
8	Байгалийн цэвэр давсыг иоджуулан боловсруулах	Хэрлэн сум 2-р баг	Давст оргил ЗГБХН	2293323	Иоджуулсан давс үйлдвэрлэл	Хэвийн	2024	тийм	5	5	Жижиг савлагаатай давс	тийм	Хэрлэн сум 2-р баг	95153285,
9	Буйдан захиалга засвар	Хэрлэн сум 2-р баг	Э.Эрдэнэбулган	ЖС89120163	Буйдан үйлдвэрлэл	Хэвийн	хаасан	тийм	6	4	хатуу тавилга, ажлын хувцас	тийм	Хэрлэн сум 2-р баг Содон тавилга	89472020, 89172020
10	Талх, нарийн боов үйлдвэрлэлээ өргөжүүлэх төсөл	Хэрлэн сум 6-р баг Ивээл	ЭнхМөнхБожу ХХК	3380777	Талх, нарийн боов үйлдвэрлэл	Хэвийн	2024	нотлогдохгүй	4	4	Аяган бялуу, Донут кекс, бургер, хотдог	тийм	Хэрлэн сум 6-р баг Ивээл	99028110
11	Дорнод өндөг бизнес төсөл	Хэрлэн сум 3-р баг	Нутгийн тус ХХК	2801787	Тахианы аж ахуй үйлдвэрлэл	Хэвийн	2024	нотлогдохгүй	6	8	Өндөг	тийм	Хэрлэн сум 3-р баг	99579941
12	Буйр нуур аялал жуулчлал	Халхгол сум Ялалт баг	Буйр трэйвел ХХК	2776421	Аялал жуулчлалын бааз	Хэвийн	2024	нотлогдохгүй	13	6	-	улирал	Халхгол сум Ялалт баг	88115499
									92	59				
2020 он														
13	Дотор мах дайвар бүтээгдэхүүн боловсруулах	Хэрлэн сум 4-р баг	Дорнод нет ХХК	2802074	Махны үйлдвэрлэл	Хэвийн	2025	тийм	4	4	Хагас боловсруулсан бүтээгдэхүүн	тийм	Хэрлэн сум 4-р баг	99582891, 88042150
14	Дорнод чацаргана	Хэрлэн сум 6-р баг 20 байр 10 тоот	Билгүүн жаргал ХХК	2094061	Чацарганы шүүс үйлдвэрлэл	Хэвийн	2025	тийм/хил гаалиас болгоод/	4	1	Байхгүй /Шинээр шүүс/ дүнгүй	зогсонги/ үр	Хэрлэн сум 6-р баг 20 байр 10 тоот	89054299, 88584299
15	Сүү, сүүн бүтээгдэхүүн	Хэрлэн сум 6-р баг СМУ	Талын сүү ХХК	3367983	Сүүний үйлдвэр	Хэвийн	2025	тийм	8	4	Мазаалай аарцтай зайрмаг, ерөм, тараг, сүү	тийм	Хэрлэн сум 6-р баг СМУ	88145556
16	Гутлын үйлдвэр өргөжүүлэх	Дашбалбар сум 2-р баг Харзат Цагаан дэв	Эрхэт цог баян ХХК	3388115	Боловсруулах үйлдвэр	Хэвийн	2025	тийм	2	2	Арьсан гутал	тийм	Дашбалбар сум 2-р баг Харзат Цагаан дэв	80818531

17	Эрүүл хүнс, дайвар	Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг 24- р хороо цахлай 64. 99588414. 80121701	Маш итгэл ХХК	2596717	Дайвар бүтээгдэхүүн боловсруулах	Хэвийн	2025	нотлодохгүй	2	0	Маш итгэл 6 төрлийн дайвар бүтээгдэхүүн	тийм	Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг 24-р хороо цахлай 64. 99588414. 80121701	99588414. 80121701
18	Дотор мах дайвар бүтээгдэхүүн боловсруулах	Дашбалбар сум Сэвсүүл жараахай баг	Улзын тулга ХХК	3371883	Мах, махан бүтээгдэхүүн дайвар бүтээгдэхүүн худалдаа	Хэвийн	2025	тийм	5	5	Дайвар бүтээгдэхүүн, бууз, банш	тийм	Дашбалбар сум Сэвсүүл жараахай баг	88726977
19	Тунамал	Хэрлэн сум 1-р баг Хэрлэн Номин бизнес төв	Түмэн олз ХХК	3377237	Сүү, цагаан идээ боловсруулах	эргэлзээтэй	2025	нотлодохгүй /гүй	7	3	Байхгүй /сүү, цагаан идээ/	гүй/ зорцуула лт өөр	Хэрлэн сум 1-р баг Хэрлэн Номин бизнес төв	99035052, 99067418
20	Баят	Дашбалбар сум Үлз баг	Баян Аят ХХК	3371255	Дайвар бүтээгдэхүүн боловсруулах	Хэвийн	2025	тийм	5	3	байхгүй	Зогсонги/ ур дүнгүй	Дашбалбар сум Үлз баг	89994949
Нийт										37	22			
Бүгд нийт										129	81			

Судалгаа гаргасан: Ахлах аудитор
албан тушаал

Гарын үсэг /Я.Зориг /
нэр

Тайлангийн хавсралт 2

2022.10.17

АЗДТГ-аас ХАС банкаар дамжуулан олгосон ЖДҮ-ийн зээлийн төслийн хэрэгжилтийн судалгаа

2022.10.17														
№	Төслийн нэр	Төслийн байршил /сууны нэр/	Зээлдэгч иргэн, ААН-ын нэр	Регистр	Төслийн чиглэл	Зээлийн ангилал /Мүү, эргэлзтэй, хэвийн/	Зээл дуусах огноо	Зээл зориулалтын дагуу эсэх /Тийм, үгүй/	Ахлын байр		Шинээр бий болсон бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр	Үйл ажиллагаа нь тогтмол явагдаж байгаа эсэх /Тийм, үгүй, улирал/	Төслийн хаг, байршил	Холбоо барих утасны дугаар
2019 он														
1	"Шим"	Баянтүмэн	Ж.Огтонбаатар		Сүү, цагаан идээ боловсруулах	хаагдсан	2023.05.18	Тийм	2	2	Тараг, сүү, өрөм, цөцгий	улирал	Баянтүмэн сум 2-р баг	88581133
2	"Нутгийн сүү" төсөл	Хэрлэн	С.Солонго		Фермерийн үйл ажиллагаа эрхэлж, сүү, цагаан идээ боловсруулах	хаагдсан	2023.05.20	тийм	2	0	Ковидын шалтгаанаас үйл ажиллагаа явуулаагүй хаасан, үхэр малаа зарсан.	Үгүй	Хэрлэн сум 8-р баг, Баяннуур	88029999
3	"Амгат царцаамаг"	Хэрлэн	"Маш итгэл" ХХК	2596717	Хагас боловсруулсан дайвар бүтээгдэхүүн үйлдвэрлэл	хэвийн	2023.05.20	тийм	12	6	хуйбалж чанасан толгойн мах, үхэр, адуу, хонины чанасан хал, адууны умс, итгэй 6 нэр төрлийн бүтээгдэхүүнийг вакуумлан савлан үйлдвэрлэнэ.	тийм	6 дугаар баг СМУ 25-4 тоот, УБ хот ЭЗД-ийн 19 хороо Да хураа 64 "Модерн классик фурнитур" ХХК-ний байр	80121701
4	"Цэвэр орчин-Эрүүл амьдрал"	Хэрлэн	Х.Намхай	жө73052019	Хуанцар сав хог хаягдал боловсруулах	хэвийн	2023.03.16	тийм	14	5	дахин боловсруулах төхөөрөмж	үгүй	Хэрлэн сумын 2 дугаар баг,	96588022
5	"Авто засвар үйлчилгээ"	Хэрлэн	Б.Батбаяр	жэ74010116	Автомашин засвар үйлчилгээ, салбэрийн дэлгүүр ажилуулах	хэвийн	2023.05.12	тийм	10	3	аклын байр	түрээс	Хэрлэн сум 10 дугаар баг,	89459898
6	"Авто салбэр, дугуй засвар"	Хэрлэн	А.Чойдалжамц	жэ80080511	Дугуй засвар гангуурын үйлчилгээ	хэвийн	2023.03.03	тийм	5	3	авто угаалга, гангуур, засвар	улирал	Хэрлэн сум 6 дугаар баг	89580799
7	Тавилга	Хэрлэн	Дорнын Номин-Эрдэнэ ХХК	3376176	Модон эдлэл, тавилга үйлдвэрлэл, барилгын материалын худалдаа	хэвийн	2023.05.05	тийм	5	3	тонотг төхөөрөмж авсан, монгол гэрийн бүх тавилга хийж байгаа	Тийм	Хэрлэн сум 9 дүгээр баг	96971111
2020 он														
8	"Түмэн сүрэг"	Матад	Баян гэгээн хуслэн хоршоо	3385531	Мах сүүний чиглэлийн үхэр өсгөх	хэвийн	2023.04.05	үгүй	9	3	үхэр худалдаж авсан /түрүүлэгч/	Тодорхойгүй	Матад сум	88588963
9	"Шинэ амт"	Баян-Уул	Д.Амгаланбаатар	ЖО84051071	Бүх төрлийн сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх	хэвийн	2025.07.21	үгүй	5	0	Байхгүй	Тодорхойгүй, баримтаар нотлогдоогүй	Баян-Уул сум	86850094
10	"Арвижих"	Хэрлэн	М.Энхтүвшин	жэ77112818	Мах сүүний чиглэлийн үхэр өсгөх сүү цагаан идээ боловсруулж зах зээлд нийлүүлэх	хэвийн	2025.07.18	тийм	8	1	тугалтай үнээ 5 өрөм тос ааруул	Улирал	Хэрлэн сумын 3 дугаар баг,	99162281
11	"Өөдлөх ирээдүй"	Чойбалсан	Б.Ариунтулгал	цэ83052061	Баруу худалдан авч, тэжээн зах зээлд борлуулж өрийн орлогоо нэмэгдүүлэх	хэвийн	2025.10.02	тийм	5	3	40 бяруу	Улирал	Хэрлэн сум 10 дугаар баг,	99041480
2021 он														
1	"Авто сервис"	Хэрлэн	Г.Оюунтуяа	жэ71051208	дугуй засвар, прусс оношлогоо	хэвийн	2026.01.02	тийм	3	2	дугуй засварын тоног төхөөрөмж	Хөдөө явсан үзүүлэгч	Хэрлэн сум 11 дүгээр баг, уурхайн	88578496

Судалгаа гаргасан: Ахлах аудитор /Я.Зориг / албан тушаал нэр гарын үсэг

Дорнод аймаг Хэрлэн сум, 7-р баг, аймгийн Засаг даргын
Тамгын газрын 2-р байр, 1, 2 давхарт
Утас: +976 7058-4203, 7058-4204, 7058-4207
И-мэйл: dornod@audit.gov.mn, Веб сайт: www.audit.mn